

МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫН ХӨГЖИЛ: УЛАМЖЛАЛ ШИНЭЧЛЭЛ

Д.ОТГОНЧИМЭГ
ОУУБИС-ийн ахлах багш

Түлхүүр үг: улс төрийн түүх, улс төрийн мэдлэг-боловсрол, улс төрийн үзэл суртал, онол арга зүй

Товч утга: Монгол улсад улс төрийн боловсрол мэдлэг олгож ирсэн түүхэн үйл явцыг тоймчлон авч, тэдгээрийн гол ач холбогдлыг төр, нийгмийн зүгээс ард иргэдэд хэрхэн ямар шат дамжлагатайгаар явуулж байсан түүхэн уламжлалын онцлогуудыг гаргахыг зорьсон.

* * *

I. Монгол улсад бүх нийтийн улс төрийн боловсрол олгож ирсэн түүхэн уламжлал. Хүн улс төрийн орчингүйгээр нийгэмших боломжгүй юм. Тэр орчинд орж төлөвшихөд улс төрийн наад захын мэдлэг шаардагдаж, улмаар улс төрийн мэдрэмж, ухамсар төлөвшдөг. Ийм учраас монголчуудын улс төрийн сэтгэлгээ дээр үеэс хөгжиж ирсэн нь мэдээж. XX зууны босгыг алхахад хүн төрөлхтөний улс төрийн амьдралд, эрс өөрчлөлт орж, өмнөх үеийнхээс шинэ соргог үзэл санаа шаардагдаж эхэлжээ. Монгол ч үүнийг тойрон өнгөрсөнгүй. XIX зууны сүүлч XX зууны эх гэхэд Монгол оронд нийгэм-улс төрийн дэвшилт ардчилсан үзэл санаа газар авч 1920-иод он хүртэл үргэлжилжээ. Эл ухамсар сэтгэлгээ 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгал, 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үзэл санааны уг сурвалж болсон байна.

Энэ цагаас хойш эрх баригч нам, төр засгаас олон түмэнд улс төрийн мэдлэг, боловсрол олгох үйл ажиллагаа хэд хэдэн үндсэн чиглэлээр хэрэгжсэн байна. Үүнд:

Нэг. Улс төрийн мэдлэг олгох ажлын эхлэл, өрнөл.

Эрх баригч МАН, ардын төрөөс иргэдэд улс төрийн мэдлэг, боловсролыг ажлыг:

1. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын бүрэн ялалтыг хангахын төлөө ухуулга, сурталчилгааны ажил. (1919-1924)
2. Нийгмийг ардчилах, нийгэм журамд дэвшин орох урьдач нөхцлийг хангахын төлөөх тэмцлийн үеийн иргэдэд улс төрийн мэдлэг төлөвшүүлэх үйл ажиллагаа (1924-1950-иад оны эх)
3. Бүтээн байгуулалт, социализм байгуулах оролдлогын үеийн улс төрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа (1950-иад оны эхнээс 1980-аад оны сүүлч хүртэл) хэмээн ангилж болох юм.

Эхний шатны улс төрийн ухуулга, сурталчилгааны ажлыг авч үзье. 1918-1919 оны заагаар байгуулагдсан Хүрээний, Консулын хэмээх улс төрийн хоёр бүлгийн үеэс ард олны дунд явуулах улс төрийн ухуулга, сурталчилгаа идэвхжсэн гэж хэлж болно. Нууц бүлгүүдийн үйл ажиллагааны нэг гол хэлбэр бол ухуулах хуудас гарган, Нийслэл хүрээний гудамж, талбайгаар нааж, хуучин засгийн ялзрал доройтол, нийгмийн бурангуй байдлыг шүүмжлэн, эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд эрслэн босохыг уриалж байсан явдал юм.

Улс төрийн ухуулга, сурталчилгааны гол үзүүр улс төрийн засаглалын асуудалд төвлөрч байв. Бидэнд уламжлагдан ирсэн цорын ганц ухуулах хуудас-“Сюй Шү-чжэний суусан хашааны хаалганд нэгэн шөнө наалдуулсан бичиг”-т (1919): “...одоогийн эрдэм ухаангүй засгийг халж, дэлхий дахины олон гадаад улсын адилаар сонгож байгуулах засгийг явуулна”¹ гэж тэмдэглэсэн нь сонгуулийн засаг, тэгэхдээ хөрөнгөтний Бүгд Найрамдах засгийн тухай үзэл санаа дэвшүүлсэн хэрэг юм. Учир нь энд “дэлхий дахин олон гадаад улсын адилаар” гэснээс тодорхой байна. Гэвч цаашид улс төрийн засаглалын үзэл санаа улам тодорхой болж, МАН хэмээх байгууллагын “Намын хүмүүсийн дагаж явах тангарагийн бичигт”-т(1920): “...Ядуу дорд ард түмний тусыг туйлаар бодох”² засгийн тухай үзэл санаа, дараа нь МАН-ын анхны мөрийн хөтөлбөр “Монгол ардын намаас түмэнд тунхаглан зарлах бичиг”-т: “...засгийн эрх мэдлийг ард түмэнд шилжүүлэн авч, ардын хурал сонгуулийг эрхэлсэн гүрэн байгуулбал зохино”³ гэж заажээ. Чингээд МАН-ын улс төрийн ухуулга, сурталчилгааны ажил ард олонд улс төрийн засаглалын тухай, нэн ялангуяа шинэ тогтох төрийн хэлбэр,

¹ МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. (1920-1940 он)I дэвтэр.УБ.1966.х-9.

² Мөн тэнд.х-7.

³ Мөн тэнд.х-32.

шинж чанарыг ойлгуулахад чиглэгдсэн байна. Энэ үед намыг үүсгэн байгуулагчид нутгийн ард олны дотор улс төрийн ухуулгыг өөрсдийн биеэр хийж, нийгмийн бурангуй байдал, хуучин засгийн доройтол, ялзралыг шүүмжлэн, улс үндэстнийхээ тусгаар тогтнол, эрх чөлөөнийхөө төлөө тэмцэхийн учрыг ухуулан таниулж байжээ. Үүнд 1920 оны 11 дүгээр сарын 20-ний анх нийтлэгдсэн “Монголын үнэн” сониныг улс төрийн ухуулга, суртал нэвтрүүлэгт өргөн ашиглаж байв.

Хоёр. Монгол Ардын Намын I их хурал 1921 оны 3 дугаар сарын 1-3-нд хуралдаж, намыг жинхэнэ ёсоор байгуулсан үеэс улс төрийн ухуулгын хүрээ, хэмжээ далайц улам дээшилж арга хэлбэр нь баяжжээ.

МАН, Ардын түр засгийн газрын бодлогын бусад аймаг, хошуудад дэлгэрүүлэн, Оросын цагаантны эсрэг тэмцэлд олон түмнийг зохион байгуулж, хувьсгалын ялалтыг хангахын тулд Намын Төв Хороо, Түр Засгийн газар, Ардын журамт цэргийн удирдах хүмүүсийг хязгаар нутагт томилон явуулах, намын суртал номлогч нарыг буй болгох, цэргийн ангиудад улс төрийн ажилтныг томилж байжээ.

Хиагтыг чөлөөлсний дараа намын мөрийн хөтөлбөр-“МАН-аас түмэнд тунхаглан зарлах бичиг”, бусад ухуулах бичгүүдийг тараажээ. Энэ явцад хамжлагат ёсны мунхаг харанхуй байдалд хүний наад захын эрх эдэлж үзээгүй ард олон сэхээрч ухааран, улс төрийн мэдлэг бага багаар олж, улс төрийн ухамсар төлөвшснөөр хувьсгалт тэмцэлд идэвхтэй оролцож, 1921 оны хувьсгалыг ялалтанд хүргэжээ.

МАН нь улс төрийн ухуулгаар дамжуулан ард олонд улс төрийн ухамсар суулган, нам, ардын засгийн улс төрийн бодлого, цаг үеийн зорилтыг тайлбарлан ухуулж, тэдний урам зоригийг сэргээн дайчилж, нийгмийг ардчиллах үйл явцыг гүнзгийрүүлж байсныг түүхэн туршлага харуулж байна.

1921-1924 оны улс төрийн ухуулга, сурталчилгааны ажил нь хамжлагат ёсыг халах, орон нутгийн засаг захиргааг ардчилахын учир холбогдлыг ард иргэдэд ойлгуулахад чиглэж байв. Энэ үед төв, орон нутагт намын үүр, хороод, ХЗЭ, эмэгтэйчүүдийн байгууллагууд олноор байгуулагдаж, тэдгээр нь улс төрийн ухуулга сурталчилгааны ажлыг явуулах гол хүч болж байлаа.

II. Улс төрийн мэдлэг, боловсролын үйл ажиллагааны хоёр дахь шатанд (1924-1950-иад оны эх)

Монголын нийгмийн амьдралыг хувьсгалт ёсоор өөрчлөн зохион байгуулах, нийгэм журамд шилжин орох урьдач нөхцлийг хангахад чиглэгджээ. Эхний шатанд улс төрийн засаглал, улс төрийн амьдралын утга учрыг тайлбарлах арга зүй, аман яриа, ухуулах хуудас, уриа бичиг, сонин бичиг зэргийг өргөн ашиглаж байсан бол хоёр дахь шатанд дээр дурьдсан арга барилаа баяжуулж, хэд хэдэн шинэлэг арга хэлбэрийг нэвтрүүлсэн байна. Тухайлбал, улс төрийн ухуулгад “...тодорхойлон ухуулах”, “сурган гэгээрүүлэх”⁴ арга зүйг голлон “сонин бичиг ... дүрэм заавар ... ухуулах хуудас, цахилгаан сүүдрийн наадам (кино-Д.О) дэвтэр сэтгүүл, толь бичиг, ухуулах, зарлах хуудас...”⁵ зэргийг ашиглан хэрэглэж байжээ.

1925 онд хуралдсан МАХН-ын II дахь мөрийн хөтөлбөрт: “Олон түмнийг гэгээрүүлэн боловсруулахдаа хувьсгалын үзэл суртлыг гол болгон үүсгэхийн дээр бас тусгайлан К.Марксын номлол, сургаалыг нэвтрүүлбэл зохино”⁶ гэж заажээ. Энэ үеэс улс төрийн ухуулга, суртал нэвтрүүлэгт марксист арга зүйг голлох болж, ард олныг ангийн тэмцлийн хуулийн мэдлэгээр цэнэглэх болсон байна. Өгүүлэгдэн буй үеийн улс төрийн ухуулгын гол онцлог бол нам, төрийн улс төр, эдийн засгийн бодлогыг ард түмэнд түргэн шуурхай хүргэж тайлбарлах явдал байна. Ялангуяа шашингүйн ухуулга суртал нэвтрүүлгийг хүчтэй болгож байв. Түүний нэг жишээ нь “Баасан гарагийн хурал” юм. Энэ хурлаар шашингүй суртал нэвтрүүлэг лекц, яриа хийж, лам нар, сүсэгтнүүдэд шашны бурангуй үзлийг шоглосон ший жүжиг үзүүлэх зэрэг ажил хийж байв. Баруунтан гэгчид үндэсний ардчилсан үзлийн үүднээс улс төрийн ухуулга хийж байхад, зүүний нугалаа завхралын үед Монголд зөвлөлт маягийн социализм байгуулах коммунист хийрхэлийг сурталчилсан улс төрийн ухуулга газар авч байв.

Зүүний алдаа завхралыг засах шийдвэр гаргасан 1932 оны Намын Төв Хороо, Хянан байцаах төв комиссын онц III бүгд хурлын дараа (энэ хурлын шийдвэр түүхэнд Шинэ эрдэмтэн бодлого хэмээн алдаршсан-Д.О) уг шийдвэрийг олон түмэнд ойлгуулах улс төрийн ухуулга, сурталчилгааны ажил ихээхэн идэвхжсэн юм. Ялангуяа шинэ эргэлтийн бодлогын мөн чанарыг олон түмэнд ойлгуулах асуудалд улс төрийн ухуулгын ажлыг төвлөрүүлж, анхаарал бичиг гаргаж байжээ.

Дэлхийн II дайны үед МАХН, Ардын төрөөс иргэдэд улс төрийн мэдлэг олгох, төлөвшүүлэх ажлын зэрэгцээ Зөвлөлтийн ард түмэнд туслах хөдөлгөөн өрнүүлэх хөдөлмөрчдийг эх оронч, интернационалч үзлээр хүмүүжүүлэхэд чиглэж байв. 1940-өөд он гэхэд ард олны улс төрийн мэдлэг, ухамсар дээшилсэн боловч эгэл хөдөөх ардууд олон зүйлийг үл ухварлан, улс төрийн амьдралаас нэлээд хол хөндий байжээ.

⁴ МАХН-ын Их, бага хурал, ТХ-ны бүгд хурал, ТХ-ны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр. I хэсэг (1921-1939). УБ. 1956. т.33.

⁵ Мөн тэнд т.31,32,33,89.

⁶ Мөн тэнд т.115.

Жишээ нь: “Б.Ширэндэв гуай “Далайн давалгаанаар” номондоо: “Зөвлөлт эх орны дайны үеэр хөдөө явж байгаад дайны талаар буруу гажууд үг яриа гаргасан нэгэн өвгөнийд хамт явсан зөвлөлтийн нэгэн сургагчтай очив. Удалгүй хавийн ардууд хэсэг хэсгээрээ уван цуван ирсээр бидний буусан айлд олон хүн цугларав. Би ч цүнхнээсээ дэлхийн газрын жижиг зургийг гаргаж, дайны явцын тухай цугларагсад нэлээд тайлбарлав.

Гэрийн эзэн шинийн архи ууж, нэлээд согтуу байсан бөгөөд надад хандан “Хүү минь, чи их худлаа ярьдаг хүн юмаа. Юу гэвэл зах хязгааргүй замбуулинг алгын чинээ цаасан дээр зурсан зураг дээр ярьж байгаа чинь итгэмээргүй” гэв. Тэнд цугларагсад миний ярианы амжилтгүй, нөгөө доогт өвгөний цэцэрхлийн чадлыг бахархан дэмжсэн шиг инээлдэв.

Би үүнээс ихэд гэмшиж үндэслэл бүхий хариу өгөхөөр хэдэн минут хэлэх санаагаа эвлүүлэн ядаж суутал хамт явсан зөвлөлтийн сургагч маань тэр айлын жаазтай бурхны хажууд байсан үнэмлэхэнд наадаг хумсын чинээ гэрэл зургийг аваад:

- Энэ хэний зураг вэ? гэж гэрийн эзнээс асуухад гэрийн эзэн өвгөн:
- Энэ бол миний хүү гэв.
- Энэ танай хүү бишээ. Та бас л худлаа ярьдаг хүн байна гэв. Өвгөн ихээхэн уурсаж
- Энэ бол миний хүү гарцаагүй мөн гэж уйлан дугарч эхлэв. Сургагч инээж:
- Таны хүү танаас өндөр үү, нам уу? гэж асуухад тэр өвгөн:
- Хүү минь надаас хамаагүй өндөр гэж хариулав. Сургагч:

Ийм том биетэй хүнийг ийм жижиг зургаар харуулж болдог болохоор, замбуулинг бас жижиг цаасан дээр дүрслэн харуулж болдог нь тодорхой байна шүү дээ гэхэд гэрт байсан хүмүүс нэгэн мөч ийн дотор ойлгож бидний ярианд итгэсэн билээ”⁷ гэж бичжээ.

Дайны жилүүдэд Намын Төв Хороо “Улс төр, гэгээрлийн ажлын байдал ба зорилгын тухай”, “Намаас олон түмний дунд явуулж байгаа ухуулгын байдал ба зорилтуудын тухай” зэрэг асуудлыг удаа дараа хэлэлцэн ухуулга, сурталчилгааны ажлыг цаг үеийн тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн олон түмний оюун санаад нөлөөлөх хүч чадлыг дээшлүүлэхийн чухлыг намын байгууллагуудад даалгасан байна. Эл үеийн ухуулга, сурталчилгааны ажлын гол хэлбэр нь аман ухуулга, лекцийн суртал нэвтрүүлэг, хэвлэл, радио, кино, утга зохиол, урлагийн янз бүрийн хэлбэрийг аль болохоор ашиглаж байсан явдал юм.

Намын Төв Хорооны дэргэд удирдах хариуцлагатнаас бүрдсэн 10 хүнтэй лекторын хэсэг, аймаг, хотын намын хороодод 6-9 хүнтэй лекторын хэсэг байгуулав. Намын Төв хорооны дэргэдэх лекторын хэсэг 1942 онд 6 аймагт явж ажилласны дээр радиогоор 48 лекц уншсан ба 1944 онд хөдөлмөрчдөд 77 лекц уншсаны дотор 11 нь олон улсын байдлын тухай, 15 нь Зөвлөлтийн ард түмний эх орны их дайны явцын тухай, 9 нь бэлэглэлийн тухай сэдэвтэй байжээ. Түүнээс гадна 1945 оны байдлаар нийт 286 лектор 21322 ухуулагч хот хөдөөгийн хөдөлмөрчдийн дотор янз бүрийн сэдвээр ухуулга, таниулга тогтмол явуулж байв.⁸

МАХН-ын Төв Хорооны 12 дугаар сарын бүгд хурлын (1940) улс төрийн ухуулгыг төвлөрсөн журамд шилжүүлэн, ухуулагчдыг үйлдвэр, албан газар, сүм багт нь 10-20 айл хариуцуулах болжээ. Улс төрийн ухуулагчдын бүлэг байгуулсан байна.

III. Бүтээн байгуулалт, социализм байгуулах оролдлогын үеийн иргэдийн улс төрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа.

Нэг. 1954 онд хуралдсан МАХН-ын XII их хурал тус улсад “социализмыг дэлгэрэнгүй байгуулах” зорилт дэвшүүлж, үүний хамт социализмын мөн чанарыг ойлгуулах улс төрийн ухуулга, суртал нэвтрүүлгийг хүчтэй болгох зорилт дэвшүүлжээ.

Ухуулгын ажлыг 1950-иад онд гол төлөв айл гэрээр явж, хэсэгчилсэн буюу ганцаарчилсан байдлаар хийж байв. Нэгдэлжих хөдгөөний үед ийм улс төрийн ухуулга тодорхой үр дүнгээ өгчээ.

1959 онд нэгдэлжих хөдөлгөөн ямны нарын улс төрийн ухуулгын арга хэлбэр өөрчлөгджээ. Бригадын өдөрлөг хийх болж, мал аж ахуйн суурьт зохиох улс төрийн ухуулга тогтмолжсон байна.

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо 1959 оны 4 дүгээр сард тогтоол гаргаж, хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн бригад бүрт ухуулагчдын хэсэг байгуулжээ.

1960-аад он 70-аад оны эх гэхэд улс төрийн ухуулга, суртал нэвтрүүлгийн ажлын арга хэлбэр баяжиж, агуулга нь өргөн цар хүрээтэй болсон байна. 1965-1971 онд дээд дунд боловсролтой ухуулагчдын тоо 50 хувиар өссөн байна. Бригадын өдөрлөг хэвшин тогтмолжиж, тэргүүн туршлагын сургууль, улс төрийн мэдээлэл зэрэг шинэ хэлбэрүүд бий болжээ.

⁷ Б.Ширэндэв Далайн давалгаанаар. УБ61993.х-161-162.

⁸ Оюун сэтгэлгээний цоморлиг (XX зуун) УБ.2013.х-36-37.

1970-80-аад онц лекцийн суртал нэвтрүүлэг өргөн дэлгэрэв. Үүнд: Монголын эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэг багагүй үүрэг гүйцэтгэсэн юм.

Ард иргэдийн ихэнх нь бичиг үсэгт тайлагдаагүй байхад сонин уншлага хийж, ухуулагчид их төлөв “Үнэн” сонины I, IV нүүрийг тоймлон уншиж танилцуулж байсан бол энэ үед улс төрийн сонсгол, улс төрийн мэдээллийн хэлбэрийг өргөн ашиглах болжээ. Эл хэлбэрээр нам, төрийн улс төрийн бодлогын мөн чанар, олон улсын байдал зэргийг тогтмол танилцуулах болсон байна. Түүнчлэн Намын их, Намын Төв Хорооны бүгд хурлын дараа ажилчин, албан хаагчдын улс төрийн мэдлэгийн шалгалт авдаг байжээ.

Хоёр. Ном зохиол, хэвлэл мэдээллээр дамжуулан улс төрийн мэдлэг олгох үйл ажиллагаа. Эрх баригч нам, ардын төр ард олонд улс төрийн мэдлэг олгох чухал хэрэгсэл нь ном, хэвлэл гэж бүр эхнээсээ үзэж, энэ асуудалд онцгой анхаарал тавьсан юм. Түүний анхны тод илрэл бол 1920 оны 11 дүгээр сарын 10-нд “Монголын үнэн” сонинг гаргаж, хувьсгалт тэмцлийн зорилтоо тодорхойлсон. “Манай зорилго” Америк, Японы империалистууд Монгол орныг эзлэхийг зүйл зүйлээр хийсэн оролдлогууд, ардын эрхт сонгож байгуулах засаг байгуулах тухай “Монголд ардын шинэ засгийг байгуулах үндсэн журам” зэрэг өгүүлэлүүдийг нийтлэж байсан явдал юм.

1921 оны 7 дугаар сараас 1922 оны 12 дугаар сар хүртэл “Уриа” сониныг гаргаж нам, төрийн улс төрийн бодлого, хувьсгалт ардчилсан өөрчлөлт монгол, зөвлөлтийн найрамдлын мөн чанарын утга учир зэргийг тайлбарлаж байсан нь ард иргэдэд улс төрийн амьдралын наад захын мэдлэг олгоход багагүй үүрэг гүйцэтгэсэн юм. Эл сонинд нам, засгийн тогтоол, шийдвэрүүдийг “Ардын намын сонин”, “Засгийн газрын хурал” гэсэн булангуудад нийтэлж байв. Цаашид “Ардын эрх” сонин гарч, үүнийг залгамжлан, 1925 оны 4 дүгээр сараас Намын Төв Хороо, ХЗЭ-ийн Төв Хорооны хэвлэл “ҮНЭН” сонин хэвлэгдсэн байна. Мөн намын гишүүд, хөдөлмөрчдийн улс төрийн мэдлэг боловсролын дээшлүүлэхэд “Монгол Ардын Нам”, “Нийгэм журмын зам” зэрэг сэтгүүлүүд чухал үүрэг гүйцэтгэжээ. Ялангуяа 1932 оны 1 дүгээр сараас хоёр долоо хоног тутам хэвлэн гаргаж байсан “Хөдөөний ухуулагч” сэтгүүл нь эгэл хөдөөх малчдын улс төрийн мэдлэг, ухамсарыг дээшлүүлэх, ухуулагч, суртал нэвтрүүлэгчдийг төвөөс ухуулгын гарын авлага, материалаар хангаж байх, ухуулагчдын туршлагыг харилцан солилцуулах, төр засгийн бодлого шийдвэрийг ухуулан таниулж, тэдэнтэй тогтоосон холбоог бэхжүүлэх шаардлагыг хангаж байв.⁹

1920-1930-аад онд сонин, хэвлэлүүдээр улс төрийн шог зураг олноор нийтэлж байсан нь тэр бүр бичиг үсэгт тайлагдаагүй үед улс төрийн нөхцөл байдлыг ойлгуулахад тус дөхөм үзүүлжээ.

1934 оноос радио өргөн нэвтрүүлэг бий болж, улс төрийн суртал нэвтрүүлэг өргөжсөн байна. МХЗЭ, МҮЭ-ийн шугамаар сэтгүүлүүд гарах болов.

1940-өөд оноос “Үнэн”, “Залуучуудын үнэн”, “Пионерийн үнэн”, “Эх орны маань”, “Хөдөлмөр” сонин, “Намын байгууллага”, “Хувьсгалт залуучуудын үнэн”, “Шинжлэх ухаан”, “Засгийн газрын мэдээ”, “Өврийн дэвтэр”, “Цэргийн бодлого”, “Матар” зэрэг сэтгүүлүүд, “Үнэн” сонин 4 дүгээр нүүрт олон улсын байдлыг тогтмол мэдээлж, бусад сонин сэтгүүлүүдэд улс төрийн амьдралын тогтмол булан нийтлэгдэх болсон байна.

1955 оноос “Утга зохиол”, “Улаанбаатарын мэдээ”, “Найрамдлын зам” сонин, 1958 оноос “Намын амьдрал” сэтгүүл гарах болов. Хэвлэл, радиог дотоод, гадаадын мэдээллээр хангах төв-“Монголын цахилгаан мэдээний агентлаг”-ийг 1958 онд байгуулжээ.

1960-1980-аад онд ажиллаж буй хүн болгон шахуу нам, засгийн төв хэвлэл-“Үнэн” сонинг захиалж, тус сониныг улс төрийн мэдээллээр хангах төв индэр гэж үзэж байв. Ийм учраас ч “Үнэн” сонин 1980-аад онд ардчилал, өөрчлөн байгуулалтын салхийг хагалж өгсөн билээ.

1920-иод оны дунд үеэс Коминтерн МАХН-ын үндэсний ардчилсан чиг шугамыг хянан засварлах замд шилжсэн үеэс бүх нийтэд улс төрийн, мэдлэг боловсрол олгох, улс төрийн ухамсар төлөвшүүлэх үйл ажиллагаа аль болох марксист агуулгаар өрнөжээ. 1925 оноос эхлэн К.Маркс, Ф.Энгельс нарын зохиол “Коммунист намын тунхаг”, “Коммунизмын зарчмууд”, “Оросын коммунист залуучуудын эвлэлийн III их хурал дээр В.И.Лениний хэлсэн үг” зэргийг монгол хэлнээ орчуулан хэвлэж нийтэлсэн байна.¹⁰ Үүнээс гадна “Октябрийн их хувьсгал”, “Ленин бол дэлийн хувьсгалын туг мөн” гэх зэрэг товхимолыг нийтэлсний гадна нам гишүүд, олон нийтэд улс төрийн боловсролд зориулсан өгүүлэл, лекцийг хэвлэн гаргах болжээ.

МАХН-ын IV их хурлын (1924) дараагаар тухайн цагийн улс төрийн амьдралын ээдрээ нугачааг тайлбарласан “Нам хэмээх юун ба нэгэн ангийг баримтлах тухай”, “Намд шургалсан батгүй этгээдийг хөөн зайлуулъя”, “Сахилга батын тухай хэдэн үгс”, “Данзанг алдаад эвлэлийг олов”, “Намын боловсролын тухай хэдэн үг” зэрэг өгүүлэлүүд Намын Төв Хорооны хэвлэлд нийтлэгдэж байв.

⁹ О.Бямбажав. Ухуулга, суртал нэвтрүүлгийн онол-практик-арга зүйн асуудал. УБ.1976.х-27.

¹⁰ Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх. (Нэмж засварласан гурав дахь хэвлэл). УБ.1985.х-115.

1928 оноос эхлэн К.Марксын “Капитал” зохиолын зарим бүлэг, Ф.Энгельсийн “Өрх гэр, өмчит хөрөнгө, төрийн үүсэл” В.И.Лениний “Коммунизм дахь “зүүний” нялхсын өвчин”, “Зөвлөлт засгийн ээлжит зорилтууд”, “Төр ба хувьсгал”, “Марксизмын гурван эх булаг, бүрэлдэхүүний гурван хэсэг” зэрэг зохиолыг орчуулан нийтэлжээ. Ийнхүү марксизм-ленинизмын эх зохиолыг уван цуван орчуулсаар 1950-иад оны эх хүрсэн юм.

1955 онд МАХН-ын Төв Хорооны дэргэд Намын түүхийн институтийг байгуулж, түүний бүрэлдэхүүнд марксизм-ленинизмын сонгодог зохиолуудыг орчуулах тасгийг бий болгосон байна. Тус тасаг В.И.Лениний зохиолын дөрөв дэх удаагийн хэвлэлийн 35 ботийг монгол хэлнээ орчуулан нийтлэх ажлыг 1967 онд дуусгажээ. Үүний хамт К.Маркс, Ф.Энгельсийн түүвэр зохиолын гурван боть, философи, улс төрийн эдийн засгийн ухаан, ЗХУКН-ын түүх зэрэг нэлээд ном зохиол сурах бичгүүдийг орчуулан хэвлүүлсэн байна.

Бүх нийтийн улс төрийн боловсролд эрдэмтэд судлаачдын бичсэн түүхийн ном зохиолууд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Тухайн үеийн түүхийн судалгааны үр дүнд туурвисан зохиолууд гол төлөв улс төрийн түүхийн агуулгатай байсан гэж хэлж болно.

Тийм зохиол бүтээлүүдийн тоонд юуны өмнө Х.Магсаржавын бичсэн “Монгол улсын шинэ төрсөн түүх” (гар бичмэл таван дэвтэр. Эл бүтээлийг 1994, 2010 онд кирилл үсгээр хэвлүүлжээ). Уулын өвгөн “Монгол газар бошгыг халах явдлыг тулгуур болгосны товч түүх” (УБ.1926). Ойдов, Цэцэнбилэгт “МХЗЭ-ийн түүхэнд холбогдох зүйлс” (УБ.1926). Ч.Бат-Очир “Монголын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг” (УБ.1927). Г.Дэмид “Улаан цэргийн хөгжсөн түүх” (УБ.1931). А.Амар “Монголын товч түүх” Тэргүүн дэвтэр. (УБ.1934). Д.Дэндэв “Монголын ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх” (УБ.1934). Х.Чойбалсан “Ардын үндэсний хувьсгалт цэргийн агуу их хөгжмийн товч зам”. Г.Навааннамжил “Монголын автономитын түүх. Гар бичмэл”, Б.Бянчуулган “Манжаас Монголыг эзэлсэн үеийн хэрэглэгдэхүүн” (УБ.1936). Цэргийн улс төрийн газраас эрхлэн хэвлүүлсэн “БНМАУ бол манай эх орон мөн”. Тэргүүн доорд дэвтэр. (УБ.1939) зэрэг олон ном бүтээл багтаж орно.

МАХН-аас 1940-өөд оноос хойшхи үед ч судалгаа болон нийгмийн ухааны бусад салбар, чиглэлийг хөгжүүлэх талаар чухалчлан анхаарахын хамт үзэл суртлын хяналт тавьж байв. Энэ үед Л.Дүгэрсүрэнгийн “Монголын ард түмний тусгаар тогтнолын төлөө тэмцэл” (УБ.1943). Л.Тойв “Хувьсгалт цэргийн 25 жил” (УБ.1946). Түүнчлэн түүхт ойн баярт зориулсан түүхийн судалгааны бүтээлүүдийн эмхтгэлүүдийг 1941, 1944, 1946 онд гаргаж байжээ.

Монгол-зөвлөлтийн эрдэмтэдийн хамтран туурвисан анхны том бүтээл “БНМАУ-ын түүх” нэгэн боть зохиол 1954 онд нийтлэгдсэнээс хойш улсын болон МАХН-ын түүхийн янз бүрийн асуудлаар эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, диссертацийн ажил олноор бичигдсэн байна.

1966-1969 онд “БНМАУ-ын түүх” гурван боть суурь бүтээл, 1967 онд “МАХН-ын товч түүх” (эл бүтээлийн бүлгүүдийг “Намын амьдрал” сэтгүүлийн 1963-1964 оны дугааруудад цувруулж нийтэлсэн, 1964 онд товхимол хэлбэрээр хэвлүүлсэн бөгөөд 1970 онд 1967 оны хэвлэлийг тэр хэвээр нь, 1985 онд нэмж засварласан гурав дахь удаа хэвлэгджээ) хамтын бүтээл нийтлэгджээ. Эдгээр бүтээлд тухайн үеийн үзэл суртлын хатуу хяналт, марксизмыг ягштал баримталсан догматик сэтгэлгээний нөлөөгөөр үзэл сурталжсан, түүхэн үнэнийг бүрхэгдүүлсэн, ХХ зууны монголын бодит байдлыг зөвтгөж магтсан зэрэг дутагдалууд байгаа хэдий боловч бүхэлдээ монголын нийгэм, түүний аж ахуй, соёл, хүн ардын аж байдлыг иргэний түүхийн аспектээр тусгасны хамт монголын төр, түүний байгууллагууд, МАХН, олон нийтийн байгууллагын түүхийг улс төрийн үүднээс авч үзэж нэгтгэн дүгнэсэн байна.¹¹

Түүнчлэн 1970-1980-аад онд улс төрийн түүхийн чиглэлээр олон арван нэгэн сэдэвт зохиол, товхимол, өгүүлэл гарчээ. Ялангуяа нам төвтэй улс төрийн системийн талаар Б.Лигдэнгийн “МАХН бол социалист нийгмийн улс төрийн системийн удирдах хүч мөн” (УБ.1978), Ж.Болдбаатарын “Социалист байгуулалтанд МАХН-ын удирдах роль өсөн нэмэгдэж байгаа нь” (УБ.1982), Ц.Буянтогтох “БНМАУ-ын улс төрийн системд МХЗЭ-ийн гүйцэтгэх үүрэг” (УБ.1985) зэрэг, монголын нийгмийн улс төрийн системд ардын төрийн эзлэх байр суурийн талаар Ц.Балхаажавын “Төрийн тухай асуудал ба ардын төрийн хувьсгалт үйл ажиллагаа” (УБ.1966), М.Санждоржийн “Ардын төрийн түүх” (УБ.1974), О.Амархүүгийн “Төрийн захиргааны дээд байгууллагууд” (УБ.1986), И.Дашнямын “БНМАУ-ын сонгуулийн систем” (УБ.1975), улс төрийн зүтгэлтнүүдийн амьдрал, үйл ажиллагааны тухайд Ш.Нацагдоржийн “Сүхбаатарын Намтар” (УБ.1943), Х.Чойбалсангийн “Сүхбаатар бол МАХН-ын жолоодогч бөгөөд түүнийг зохион байгуулагч” (УБ.1955), “Ардын баатар Магсаржав” (УБ.1942), Б.Ширэндэвийн “Хичээнгүй сайд Цэрэндорж” (1868-1928) (УБ.1965), Д.Ядамсүрэнгийн “Ардын төрийн ахмад зүтгэлтэн Балингийн Цэрэндорж” (УБ.1967), Л.Бат-Очир, Д.Дашжамц нарын “Д.Сүхбаатарын намтар” (УБ.1969), Б.Ширэндэвийн “Ардын Хатанбаатар

¹¹ А.Жамбал. 1920-иад оноос 1980-аад оны үед Монголд хийгдсэн улс төрийн судалгааны тухайд, “Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжил, хандлага” (Эрдэм шинжилгээний бага хурал. УБ.2010.х-15)

Магсаржавын намтар” (УБ.1978), Ичинноровын “Монголын ард түмний гарамгай хүү” (УБ.1983), Д.Дашийн “Д.Сүхбаатарын тухай түүхэн тэмдэглэл” (УБ.1988), “А.Дашийн “Солийн Данзан” (УБ.1990), Л.Бат-Очирын “Бодоо сайд” (УБ.1991) зэрэг бүтээлүүдийг онцлон нэрлэж болох юм.

1990-ээд он хүртэлх үед манайд хийгдэж байсан улс төрийн аспекттэй судалгаа, боловсруулалтын хүрээн дотор улс төрийн ерөнхий мэдлэг бүрдүүлж бий болгох, түүнийг холбогдох сурах бичиг, гарын авлага, сэдэвчилсэн эмхтгэл, толь бичиг, лавлах материал зэрэг хэлбэрээр эмхлэн системчилж их, дээд, тусгай, дунд болон техник-мэргэжлийн сургуулиудын оюутан, суралцагчид, нам, үйлдвэрчний болон залуучуудын эвлэлийн улс төрийн сургуульд зориулж нийтлэн гаргаж байсан билээ. Тэр цагт одоогийн улс төрийн шинжлэх ухааныг албан ёсоор хүлээн зөвшөөрдөггүй, бие даасан тусгай шинжлэх ухаан гэж үздэггүй байсны улмаас түүний онолын мэдлэгийн тогтолцоог “Улс төрийн мэдлэг”, “Улс төрийн мэдлэгийн үндэс” гэх зэргээр нэрлэн томъёолж марксист онол, сургаалын үндсэн дээр боловсруулж нийтэд судлуулан түгээж байв. Тэрхүү судалгаа боловсруулалт, сургалт сурталчилгааг хэвлэл нийтлэлийн баримт болж гарсан ном бүтээл нэлээд бий бөгөөд тэдгээрийн заримыг дурдвал: “Улс төрийн товч толь” (УБ.1964), “Улс төрийн боловсролын анхны мэдэгдэхүүн” (УБ.1972), Б.Дүгэрийн “Нийгэм улс төрийн товч толь” (УБ.1973), “Улс төрийн мэдлэгийн үндэс” (УБ.1975), “Улс төрийн лавлах” (УБ.1986) гэсэн бүтээлүүд юм.¹²

Улс төрийн шинжлэх ухааны бүтцэд чухал байр эзэлдэг улс төрийн сэтгэлгээ, сургаалын түүхийг судлах талаар 1990-ээд оноос өмнө зарим ахиц дэвшил гарсныг үгүйсгэх аргагүй юм. Тухайлбал, академич Ч.Жүгдэр Монголын философийн түүхийн талаар дөрвөн дэвтэр бүтээлийг туурвисны дотор “ХІХ-ХХ зууны заагдах монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил” (УБ.1972) гэсэн нэгэн сэдэвт бүтээлд Монголын ХХ зууны эхэн ба дунд үеийн нийгэм-улс төр, философи сэтгэлгээний асуудлыг багтаан авч үзсэн нь энэ үеийн улс төрийн философийн түүхийн судалгаанд нэн чухал ач холбогдолтой болсон юм. Мөн ХХ зууны үеийн нийгэм-улс төрийн сэтгэлгээг хөгжүүлэх үйлсэд Монголын анхны академичдын нэг, профессор Д.Төмөр-Очир, академич С.Норовсамбуу зэрэг эрдэмтдийн бүтээл багагүй үүрэг гүйцэтгэсэн билээ.

Гурав. Намын гэгээрлийн системээр намын гишүүд, олон нийтэд улс төрийн мэдлэг, боловсрол олгох үйл ажиллагаа. 1928 оноос марксист-ленинист улс төрийн боловсролыг намын гишүүдэд дугуйлангаар судлуулах ажил эхэлжээ. МАХН-ын Төв Хороо 1932 оноос эхлэн намын гишүүдэд марксизм-ленинизмын эх зохиол, намын цаг үеийн тогтоол шийдвэр, ардын засгийн хууль дүрмийг судлуулах болсон байна. БХК(б)Н-ын түүхийн товч суралцахыг монголоор орчуулан нийтэлж, 1939 оноос намын гишүүдээр судлуулах болжээ. Намын байгууллагууд хот, хөдөөд намын гишүүдийн боловсрол мэдлэгээр нь дээд, доод дугуйланд хуваарилан суралцуулах, Улаанбаатарт намын идэвхтний оройн сургууль байгуулах зэрэг ажлыг зохион байгуулав. Сумын намын үүрийн сар бүрийн гэгээрлийн хурлыг 3-10 хоногийн сургууль болгон өөрчилж, тэдний улс төрийн мэдлэгийг дээшлүүлэх тусгай төлөвлөгөөгөөр хичээллэх болжээ. Ард иргэдийн дунд явуулах улс төрийн ажлыг сайжруулах зорилгоор Намын Төв Хорооны суртлын бригадыг орон нутагт ажиллуулах болсон байна.

Дэлхийн II дайны жилүүдэд бүх нийтийн улс төрийн мэдлэг, улс сонор сэрэмжийг дээшлүүлэхэд эрх баригч нам, ардын төрийн зүгээс ихээхэн анхаарал тавьж байв. Намын Төв Хороо намын гишүүдийн улс төрийн боловсролын системийг өөрчлөн зохион байгуулжээ. Хот суурин газарт намын гишүүдийн боловсрол, бэлтгэлийн байдлыг харгалзан намын гурван шатны дугуйлан зохион байгуулж, доод дугуйлан Намын Х, Улсын VIII их хурлын шийдвэр, намын мөрийн хөтөлбөр, дүрэм, БНМАУ-ын Үндсэн хуулийг (1940 он), дунд дугуйланд “Манай эх орон” ном, Монголын хувьсгалын товч түүхийг, дээд дугуйланд БХК(б)Н-ын түүхийг судлуулж, дугуйлангийн хичээл явуулах арга маягийг өөрчлөхийн хамт хөдөөгийн намын гишүүдэд улирал тутам 8 хоногийн хичээл явуулж байх болов. Үүгээр намын улс төрийн боловсролын нэгдмэл системийн үндэс тавигджээ.

Дайны дараа энх цагийн бүтээн байгуулалтын жилүүдэд намын гэгээрлийн системийг өргөтгөж, 1946 онд улс төрийн боловсролын системээр “Хоёрдуулан зөрчлийг олох ухаан (Диалектик материализм), “Түүхийн махбодь” (Түүхэн материализм), 1947 оноос Улс төрийн эдийн засгийн ухааныг системтэй судалж эхэлжээ.

Намын Төв Хороо 1963, 1967 онд намын улс төрийн боловсролын системд өөрчлөлт оруулсан байна. Энэхүү шинэ систем нь улс төрийн анхан шатны ба дунд шатны сургууль, онолын семинараар марксизмын бүрэлдэхүүн хэсгүүдийг дэс дараа, залгамж холбоотой, нам, төрийн бодлого, бүтээн байгуулалтын чухал асуудалтай нягт холбоотой судлуулах сонсогчдын бие даасан ажиллагаа, бүтээлч хандлага хөгжүүлэхэд чиглэгджээ.

Намын гишүүд, идэвхтний онолын мэдлэгийг дээшлүүлэх, шинжлэх ухааны коммунизмыг үндэслэгчдийн үзэл санааны өвийг судлахад улам илүү анхаарлаа төвлөрүүлэх болжээ. Ийм учраас Намын Төв Хороо 1971 онд намын улс төрийн сургуулийн системд зарим өөрчлөлт оруулж, нам, төрийн цаг үеийн бодлого, намын

¹² Мөн тэнд т.20.

үзэл суртал-зохион байгуулалтын асуудал, шинжлэх ухааны шашингүй үзэлийн үндэс зэрэг хэд хэдэн хичээлийг нэмж оруулах болсон байна. Улс төр, онолын мэдлэгээ бүтээн байгуулалтын практик, төрийн нийгэм-эдийн засгийн бодлоготой нягт холбон судлуулахад зохих анхаарал тавьж, улс төрийн сургуулийн сонгогчдоор үйлдвэрлэл, эдийн засгийн тодорхой асуудлаар судалгаа хийлгэх, хөдөлмөрчдөд улс төрийн тулгамдсан асуудлаар лекц, яриа хийлгэх, практик даалгавар гүйцэтгүүлэх, реферат бичүүлэх зэргээр бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх алхмууд хийж байжээ.

Намын Төв Хороо суртал нэвтрүүлэгч, сонсогчдод тусламж болгож, “Улс төрийн сургууль” сэтгүүлийг 1971 оноос гаргах болов. Улаанбаатар хотын намын хорооны дэргэдэх Марксизм-ленинзмийн оройн их сургуульд сэтгүүлчдийн болон урлагийн ангийг нээж, Дархан хотын Намын хорооны дэргэд Марксизм-ленинзмийн оройн их сургуулийг байгуулсан байна. Түүнчлэн 1980-аад дунд үеэс Эрдэнэт хотын намын хорооны дэргэд ийм сургууль байгуулж, янз бүрийн, ялангуяа инженер-техникийн ажилтнуудыг хамран сургах болжээ. Эдгээр сургууль нь төрөл бүрийн мэргэжлийн хүмүүст улс төрийн боловсролыг системтэй олгоход чиглэгдэж байв.

1960-аад оны эцэс хүртэл намын улс төрийн боловсролын системд анхан ба дунд шатны сургууль зонхилж байсан бол 1970-аад оны эцсээс сонсогчдын дийлэнх нь дунд шатны сургууль онолын семинарт суралцах болов. 1971 оны байдлаар дээд боловсролтой төрөл бүрийн мэргэжлийн сэхээтэн, нам, улсын удирдах ажилтнууд нийт суртал нэвтрүүлэгчдийн 90 хувь нь байсан бол 1981 онд 96 хувь болон өсчээ.¹³ Түүнчлэн МҮЭ, МХЗЭ-ийн эвлэлийн шугамаар улс төрийн сургууль хичээллэж байсан юм. Ингэхлээр, бүх нийтэд улс төрийн сургуулиар улс төрийн мэдлэг, боловсрол олгох нэгдсэн тогтолцоо бүрэлдсэн гэж хэлж болно. Мэдээж, энэ үед марксист онол-арга зүйн үүднээс ангич байр суурьнаас улс төрийн мэдлэг, боловсрол олгож байсан хэдий ч хүн төрөлхтөний улс төрийн амьдралд шаардлагатай нийтлэг ойлголт, мэдээллүүдийг бас өгч байсныг үгүйсгэх аргагүй юм. Эл үйл ажиллагааны дэвшилтэт тал нь бие хүний улс төрийн нийгэмшил, хамтач үзэл санаа суулгахад яах аргагүй нааштай нөлөө үзүүлж, хувийн эрх ашиг, нийгмийн эрх ашгийн харилцан шүтэлцээг хангахад чухал нөхвөр болж өгч байсныг тэмдэглэх хэрэгтэй юм.

Дөрөв. Бүх шатны сургуульд улс төрийн мэдлэг, боловсрол олгох үйл ажиллагаа. Ардын засгийн анхны жилээс бага сургууль байгуулж, түүний сургалтын төлөвлөгөө хөтөлбөрт, сурагчдад улс төрийн мэдлэг, боловсрол олгоход чиглэсэн хичээллүүдийг оруулж байжээ. 1925 онд хуралдсан Багш нарын II хурлаас баталсан гурван жилийн сургалттай бага сургуулийн сургалтын төлөвлөгөөнд “Улс төр” хэмээх хичээлийг долоо хоногт 2 цагаар орох¹⁴, 1926 оны баталсан дунд сургуулийн дүрэмд “Дэлхийн байдал”, “Тус улсын түүх, газар орны байдал”, “Улс төрийн байдал” хэмээх улс төрийн мэдлэг, боловсрол олгох хичээллүүдийг оруулахаар зааж, хэрэгжүүлж байв.¹⁵

1928 онд хуралдсан МАХН-ын VII их хурлаас гаргасан “Эрдэм соёлын тухай” тогтоолд: “...нийт ардыг улс төрийн суртал лугаа танилцуулахыг чухалчилваас зохино. Мөнхүү улс төрийн суртал нэвтрүүлэх, боловсруулах зардлыг орон нутгийн төлөвлөлд оруулах”¹⁶-аар заасан байна.

1934 онд баталсан сургуулиудын нэгдсэн төлөвлөгөөгөөр “Дэлхийн байдал” хичээлийг гуравдагаар ангид 60 цаг, дөрөвдүгээр ангид 60 цаг, “Улс төр” хичээлийг нэг, хоёрдугаар ангид 30 цаг, гурав, дөрөвдүгээр ангид тус бүр 60 цаг, тав, зургаа, долоодугаар ангид “Дэлхийн байдал”-ыг долоо хоногт тус бүр гурван цаг, “Улс төр”-ийг долоо хоногт тус бүр дөрвөн цаг орохоор болсон байна.

1935 оны 4 дүгээр сард Гэгээрүүлэх яам улс төрийн хичээлийн заалтын тухай 63 дугаар тушаал гаргажээ. Энэ тушаалд Улс төрийн хичээлийн заалт туйлын сул байгааг тэмдэглээд, сургуулиудад улс төрийн хичээлийг зөв сайхнаар зааж, улс төрийн хүмүүжлийг хангамжтайгаар өгөх явдал нь онцын чухал” гэж заасан байдаг.

Багшийн сургууль, санхүүгийн сургууль, Хоршооны сургууль зэрэг мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургуулиудад ч түүх, дэлхийн байдал, улс төрийн хичээллүүдийг тодорхой хэмжээгээр заасар байсан юм. 1940-өөд онд баримтлаж байсан сургалтын төлөвлөгөөгөөр I-10 ангид түүх 578 цаг, “Үндсэн хууль”, “Улс төр” 136 цаг орж байжээ. Харин энэ үеэс 1960-аад оны эх хүртэл “Үндсэн хууль” хэмээх хичээл сургалтын төлөвлөгөөнд орж, долоодугаар ангид долоо хоногт хоёр цагаар 68 цаг орж байсан байна. Харин 1960-аад оноос 1980-аад оны сүүлч хүртэл “Нийгэм судлал” хэмээх хичээл 10 дугаар ангид орох болжээ. Мөн Монголын болон дэлхийн дахины түүхийн хичээлээр улс төрийн боловсрол олгож байв. Тус хичээлээр марксизмын бүрэлдэхүүний гурван хэсгийг судалж байсан бөгөөд ШУКО-ын хэсэгт улс төрийн шинжлэх ухааны мэдэгдэхүүн, ойлголт өгч байжээ.

¹³ Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх (Нэмж засварласан гурав дахь хэвлэл). УБ.1985.х.-470

¹⁴ Ш.Шагдар. Монголын боловсролын түүх. (Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ.2009.х.-235)

¹⁵ Мөн тэнд х.-242.

¹⁶ Монгол Ардын Хувьсгалт Намын VII их хурал (Дэлгэрэнгүй тайлан)УБ.

Их, дээд сургуульд улс төрийн мэдлэг, боловсрол олгох ажлыг 1942-1943 оны хичээлийн эхэлж, МУИС-д марксизм-ленинзмийн хичээлийг тус сургуулийн бүх ангид заах болжээ. 1944 онд эдгээр хичээлийг хариуцан заах үүрэг бүхий марксизм-ленинизм, түүх кафедрьг байгуулав. 1947 онд МАХН-ын Төв Хорооноос УТС-ийн хичээл сурлагын дүнг шалгаад, марксизм-ленинзмийн үндсийг судлах явдал ёс төдий явж ирсэн гэж дүгнээд, "Марксист шинжлэх ухаан намын түүх, улс төр, эдийн засаг, философийг сайн эзэмшиж чаддаг түүнчлэн эдгээр ухааныг зөвхөн мэдээд зогсохгүй эрдэм шинжилгээний ажлыг хийдэг ба мөнхүү ухааныг дээд ба дунд сургуульдаа зааж чадах чадвар бэлтгэл бүхий шинэ хүчнийг гаргахын тулд одоогоос эхлэн бэлтгэлийг хийж ирэх хичээлийн жилээс Нийгмийн ухааны факультетийг нээсүгэй"¹⁷ хэмээх 5 дугаар хурлын тогтоолыг гаргажээ.

1947-1948 оны хичээлийн жил МУИС-д НУФ-ыг 59 оюутантайгаар нээсэн байна. Энэ нь сургуулийн нийт оюутны 13,4 хувийг эзэлж байв.¹⁸

1949 онд Нийгмийн ухааны факультетийн түүхийн салбарын анхны төгсөлт болж, хожмын Монголын түүхийн нэрт эрдэмтэн, академич Х.Пэрлээ нарын 15 хүн төгсөн гарч, дотооддоо бэлтгэгдсэн анхны дээд боловсролтой түүхч мэргэжилтэн бэлтгэх анхны шанг татжээ.

Анхны түүхч мэргэжилтнүүд бол Монгол оронд бүх нийт болон оюутан сурагчдад улс төрийн мэдлэг боловсрол олгох гол хүч болж байв.

1960-аад он бол ЗХУ коммунизмын материал-техникийн бааз байгуулах, Европын социалист орнуудад хөгжингүй социализм байгуулах зорилт дэвшүүлсэн тун дэвэргэн үе байв. Үүнийг БНМАУ ч тойрон өнгөрөөгүй юм. 1960-аад оноос тус улсад социализм бүрэн байгуулах зорилт дэвшүүлэв. Ийм учраас оюутан залууст улс төрийн боловсрол олгох ажлыг сайжруулах, улс төрийн хүмүүжил төлөвшүүлэх асуудалд онцгой анхаарал тавьжээ. 1964 онд дээд, дунд, тусгай мэргэжлийн сургуулийн нийгмийн ухааны багш нарын зөвлөгөөн хийсэн байна. 1964-1965 оны хичээлийн жилээс дээд сургуулиудад Шинжлэх ухааны коммунизмын онолын хичээлийг зааж эхлэн, Монгол Улсын Их Сургуульд Философийн анги нээжээ. Дээд сургуулиудад нийгмийн ухааны хичээл заах дэс дараалал тогтоож, нийгмийн ухааны түшиц тэнхмүүд байгуулагдав.

Хуучин тогтолцооны үед Шинжлэх ухааны коммунизмын онол бол социализмын улс төрийн шинжлэх ухааны үндэс болж байв. 1965 онд МУИС-д ШУКО-ын тэнхим байгуулагджээ. Тус тэнхим нь ШУКО төдийгүй ЗХУКН-ын түүх, улс төрийн сэтгэлгээний түүхийг эрхлэн зааж байжээ. Тус тэнхимийг хөл дээр босгож, олон түмний улс төрийн мэдлэг боловсрол олгоход философийн ухааны доктор, профессор Д.Содномгомбо томоохон үүрэг гүйцэтгэснийг онцлон тэмдэглэж байна.

Багш нарын бүтээл, туурвил эрс өсөн нэмэгдэж, 1969 онд ШУКО-ын сурах бичгийг зохиомжлон хэвлүүлсэн байна. МУИС-ийн оюутан нийгэм-улс төрийн дадлага олгох ажлын голыг тус тэнхим нугалж байсан юм.

1982 онд Д.Сүхбаатарын нэрэмжит Намын дээд сургуульд ШУКО-ын тэнхим байгуулагдаж, эрхлэгчээр нь түүхийн ухааны дэд эрдэмтэн Ж.Болдбаатарыг томилжээ. Тус тэнхимийн анхны багш нар түүхийн дэд эрдэмтэн, доцент П.Дорж, доцент Х.Зандраавал, багш Ч.Ган-Өлзий, П.Доржсүрэн, Д.Ганбат, А.Пагма нар байв. Тус тэнхим ШУКО, Олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний түүх, ЗХУКН-ын түүхийн хичээлийг эрхлэн зааж байжээ. Тус тэнхимд ЗХУ-аас доктор, профессор А.Ермолаев, дэд эрдэмтэн, доцент К.Спицын нар ажиллаж, ШУКО-ын хөгжилд гарсан хамгийн сүүлийн үеийн ололтыг сонсогчдод хүртээж байв. Бусад их, дээд сургуулийн Нийгмийн ухааны тэнхмүүдийн бүрэлдэхүүнд ШУКО-ын багш нар ажиллаж байсан юм. Ийнхүү ШУКО социализмын улс төрийн шинжлэх ухааны үүрэг гүйцэтгэж, дээд боловсрол, мэргэжилтэй боловсон хүчинд улс төрийн боловсрол олгох гол хичээл болж байсан байна.

1921-1980-иад онд бүх нийтэд улс төрийн мэдлэг, боловсрол олгох үйл ажиллагаа МАХН-ын удирдлагаар марксист онол-арга зүйн үүднээс улс төрийн ухуулга, сурталчилгаа, ном хэвлэл, нам үйлдвэрчин, ХЗЭ-ийн гэгээрлийн систем, бүх шатны иргэний сургуулийн тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлж иржээ. Эдгээр бүх ажил нь хэдийгээр марксист агуулгатай, ангич нэг талыг барьсан шинжтэй байсан боловч, дэлхий дахинд дахь улс төрийн шинжлэх ухааны нийтлэг ойлголтуудыг олон нийтэд танин мэдүүлж, улс төрийн хараа, билгийн мэлмийг нээсэн билээ.

IV. Өнөөгийн улс төрийн боловсрол олгох төрийн бодлого, түүний хэрэгжилт, тулгамдсан асуудлууд.

1980-аад оны эхний хагас гэхэд "хүйтэн дайн"-ы илт сөргөлдөөн зөөлөрч, намжмал байдал руу хэвийж, их гүрнүүдийн гадаад бодлогод шинэ сэтгэлгээ давамгайлах хандлагатай болж иржээ. Энэ үед ЗСБНХУ

¹⁷ МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1947 оны 2 дүгээр сарын 1-ний өдрийн 5 дугаар хурлын тогтоол.

¹⁸ Нийгмийн шинжлэх ухааны сургууль. (Түүхэн тойм, баримтын эмхтгэл) Нэмж засварласан 2 дахь хэвлэл УБ 2012 х-7.

болон социалист орнуудад хямралт шинж байдал ил болж, социализмын хөгжлийг бодитойгоор үнэлэн дүгнэх түүхэн шаардлага тулгарав. Улсын аюулаас хамгаалах байгууллагын олон жил толгойлж байсан Ю.В.Андропов бээр Л.И.Брежневийн оронд 1982 онд Зөвлөлтийн нам, төрийн толгойд гарч ирж, зөвлөлт нийгэмнд бугшсан хоосон сайрхал, магтаал, хээл хахуул, ёс суртахууны ялзралд идэгдэж байгаатай захиргааны аргаар тэмцэж эхэлжээ. 1982 оны 11 дүгээр сарын дундаас 18 сайд, муж, хязгаарын болон Бүгд Найрамдах Улсуудын Намын Төв Хорооны 37 нарийн бичгийн дарга нарыг өөрчилж, удирдах албан тушаалын олигархи хэсгийг тэвдүүлсэн билээ.¹⁹ Ю.В.Андропов 1983 нд “Карл Марксын сургаал ЗСБНХУ-ын социалист байгуулалтын зарим асуудал” өгүүлэл бичиж, социалист нийгмийн тухай сайрхаж байсан олон асуудлыг дахин эргэцүүлэхийг сануулсан байна. Тухайлбал, өмчийн харилцааны талаар “Миний” гэсэн хувийн өмчийн үзлийг “манай”, нийтийн гэсэн үзэл болгон хувиргах нь амаргүй хэрэг гэдгийг бодит социализмын түүхэн туршлага харуулж байна. Өмчийн харилцаанд эргэлт хийх нь үйлдвэрлэлийн үндсэн хэрэгслийг нийт ард түмний хүртээл болгочихдог ганц удаагийн үйл ажиллагаа биш ээ. Эзний эрх олж авах, ухаалаг, арвинч хямгач, жинхэнэ эзэн болох хоёр бол адилхан зүйл огт биш ээ. Социалист хувьсгал хийсэн ард түмэн нийгмийн бүх баялгийг дангаараа гол өмчлөгч байх шинэ байдалдаа дадаж занших, эдийн засгийн хувьд ч, улс төрийн хувьд ч, цаашилбал хамтач ухамсар, зан харилцаа эзэмшин сэтгэл санааны хувьд ч дасч дадахад нэлээд их цаг хугацаа орно.

“Миний” гэдгийг “Манай” болгох тухай ярихдаа энэ бол хялбарчилж үл болох олон талтай, урт удаан процесс гэдгийг мартаж болохгүй. Социалист үйлдвэрлэлийн харилцаа бүрмөсөн тогтсон үед ч хувиа хичээх заншил, бусдын хүчээр, нийгмийн хүчээр амьдрах эрмэлзэл зарим нэг хүнд байсаар байдаг, тэр ч байтугай сэргэн гарч ирдэг юм. Энэ бүхэн нь Марксын нэр томъёог хэрэглэн өгүүлбэл, хөдөлмөрийг хүнийсгэхийн уршиг бөгөөд хэдийгээр хүнийсгэлийг нэгэнт устгасан ч гэсэн энэ уршиг хүний ухамсраас гэнэт, аяндаа арилчихгүй юм”²⁰ хэмээн нийгмийн өмч бүрэлдэх нь тун амаргүй урт удаан хугацааны үйл явц гэдгийг сануулсан байна. Зөвлөлт нийгмийн хүрсэн төвшинг хэт дэвэргэн магтаж байсанд шүүмжлэлтэй хандан, “Ямар шатанд явж байгаагаа бид ухаалгаар үнэлэх хэрэгтэй. Урагш хэт яарвал биелшгүй зорилт дэвшүүлэхэд хүрнэ гэсэн үг. Хүрсэндээ тайвшран зогсвол байгаа бүхнээ ашиглаж чадахгүйд хүрнэ гэсэн үг. Манай нийгмийг бодит хөдөлгөөн дунд нь, байгаа бүх боломж, эрэлт хэрэгцээний нь хамт авч үзэх нь өнөөгийн шаардлага болж байна”²¹ дүгнэлт хийсэн юм.

Ю.В.Андроповыг насан өөд болсоны дараа ЗСБНХУ-ын нам, төрийн жолоон дээр М.С.Горбачев гарч иржээ. ЗХУКН-ын 1985 оны IV сарын бүгд хурал, улс орны улс төр, нийгэм-эдийн засгийг шинэчлэх хурдасгах зорилт дэвшүүлсэнээр ЗХУ-д шинэчлэлтийн үе эхэлүүлсэн юм. Тус бүгд хурал дээр М.С.Горбачев: “Манай орны түүхэн хувь заяа өнөөгийн ертөнцөд социализмын эзлэх байр суурь нь бид цаашид ажил төрлөө хэрхэн явуулахаас олон талаар хамаарна. Бид шинжлэх ухаан-техникийн хувьсгалын ололтыг өргөн ашиглаж, аж ахуйг социалист ёсоор эрхлэн хөтлөх хэлбэрүүдийг өнөөгийн нөхцөл, хэрэгцээ шаардлагатай нийцүүлэн, нийгэм-эдийн засгийн дэвшлийг ихээхэн түргэтгэх ёстой. Өөр зам ерөөсөө байхгүй”²² хэмээн онцлон тэмдэглэсэн юм. Энэ нь хөгжлийн хурдыг жирийн нэг түргэсгэх биш, хөдөлгөөнийг зүгээр нэг хурдасгах биш, харин социалист нийгмийг чанарын шинэ заагт гаргах асуудлыг дэвшүүлсэн хэрэг байлаа. Энэ нь арай хожуухан “өөрчлөн байгуулалт” хэмээх стратегийн ухагдахуунаар солигджээ. М.С.Горбачев: “Өөрчлөн байгуулалт бол тулгамдсан хэрэгцээ”, “Өөрчлөн байгуулалт бол хувьсгал мөн” гэж томъёолж байлаа. Үүний хамт “Ил тод байдал” хэмээх ухагдахуун, “Гласность” хэмээх орос үг улс төрийн хэллэгт баттай орж иржээ. Ил тод байх нь нэг талаас ардчиллын үр дүн, нөгөө талаас түүний хөгжин дэвших нөхцөл, хөрс дэвсгэр гэдгийг зөвлөлтийн удирдагч бүх талаас нь нотолж байсан юм. Өөрчлөн байгуулалтын нэг гол үзэл сурталч А.Н.Яковлев: “Ил тод байдал бол нийгмийг ардчилах хэлбэр, арга хэрэгсэл, ирээдүйн нийгмийн зэвсэг” хэмээн тэмдэглэж байлаа. М.С.Горбачев хүн төрөлхтний үнэт зүйлийг ангийн эрх ашгаас дээгүүр тавих өмнөх сэтгэгчдийн үзэл санааг өөрийнхөө гадаад бодлогын албан ёсны үзэл баримтлалын гүн ухааны үндэс болгосон юм. Энэ нь “Улс төрийн шинэ сэтгэлгээ” хэмээн алдаршсан билээ.

М.С.Горбачев: “Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ” номондоо: “Бид цөмөөрөө шавь нар, харин амьдрал цаг хугацаа бол багш юм. Өөрчлөн байгуулалтыг үгийн өргөн утгаар хийсний үр дүнд дэлхий ертөнц ойртон нягтрана гэсэн ойлголт өсөн өрнөнө гэдэгт би итгэж байна. Бид манай гол багш болсон амьдралаас нааштай үнэлэлт олж аваад нүдээ тайлсан бөгөөд дэвшил хөгжил үргэлжлэнэ гэсэн итгэлтэйгээр XXI зуунд орно”²³ гэсэн ирээдүйдээ бат итгэсэн үгээ хэлжээ.

Өөрчлөн байгуулалт нь ЗХУ-ын “дагуул” орон гэж нэрлэгдэж байсан БНМАУ-д шууд нөлөөлж эхэлжээ. МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн

¹⁹ XX зууны дэлхийн түүх. УБ. 2001. х-69.

²⁰ Ю.В. Андропов Карл Марксын сургаал ЗСБНХУ-ын социалист байгуулалтын зарим асуудал. УБ. 1983. х-8-9.

²¹ Мөн тэнд. х-25.

²² М.С. Горбачев. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг. УБ. 1986. х-2.

²³ М.С. Горбачев. Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ. Манай оронд болон дэлхий дахинд. УБ. 1988. х-315.

дарга Ж.Батмөнх МАХН-ын XIX их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан илтгэлдээ: “Намын Төв Хороо тус улсын эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх явдлыг чиг баримжаа болгож байна”²⁴ гэж тэмдэглэсэн нь дэлхийн социализмын өмнө тулгарсан зорилтыг тодорхой хэмжээнд мэдэрч, тус улсын эдийн засгийг эрчимжүүлэх асуудлыг дэвшүүлсэн хэрэг байлаа. Тус их хурал “... улс төрийн сургуулийг улам боловсронгуй болгох, улс төр, олон түмний ажлын үр нөлөөг дээшлүүлэх ..., гадаад улс төрийн суртал нэвтрүүлгийг хүчтэй болгох”²⁵ шийдвэр гаргажээ.

МҮЭ-ийн XIII их хурал (1987) дээр Ж.Батмөнх “Өөрчлөн байгуулалт бол манай чиг баримжаа мөн” гэсэн өмнөхөөс илүү тодорхой томъёолол хэлсэн байна. Энэ нь өөрчлөн байгуулалтыг анх удаа албан ёсоор хүлээн зөвшөөрсөний хувьд онцгой ач холбогдолтой байлаа. Гэвч социалист нийгмийн зогсонги байдлын шалтгаан, үндсийг, түүнчлэн нийгмийн амьдралын бүх хүрээнд бий болсон саатуулагч механизмыг бүх талаас нь задлан шинжлэх чадвар, шинэ сэтгэлгээ, улс төрийн зориг тэр үеийн монголын удирдагчдад дутаж байсан билээ. Энэ үед хуучныг баримталсан зан төрх, хөшүүн хойрго араншин, үзэл бодлынхоо бүдүүвчинд таараагүй бүхнийг үл тоомсорлон ихэмсэглэх авир, нийгэм-эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хойргоших, хүрсэн үр дүнгээ тоон үзүүлэлтээр дөвийлгөн магтах хандлага давамгайлсаар байв.

Харин олон түмэн улс төрийн шинэ сэтгэлгээг талархан хүлээж авч, дэвшилтэт сэхээтэн, эрдэмтэд дэлхий дахины болон социализмын улс төрийн мөн чанарыг танин мэдэх эрмэлзэл эрс өсчээ. Өөрөөр хэлбэл, олон түмний нийгэм-улс төрийн идэвх хүчтэй өрнөх болсон байна. Төр засгийн зүгээс “Өөрчлөн байгуулалт”, “Ил тод байдал”, “Улс төрийн шинэ сэтгэлгээ” зэрэг асуудалд зохих ёсоор анхаарч, “Үнэн” сониноор дамжуулан сурталчилгаа хийж, улс төрийн амьдралын шинэ соргог өөрчлөлтийг ухуулан таниулж байв.

Энэ марксизм-ленинзмийн эх зохиолуудыг сталинчлагдсан агуулгаар тайлбарлаж байсныг засах залруулах зарим нэг оролдлого хийх болов. Тухайлбал, В.И.Лениний “Сүүлчийн өгүүлэлүүд”-ийг шинэлэг байдлаар тайлбарласан өгүүлүүд “Үнэн” сонин, “Намын амьдрал”, “Залуу үе” сэтгүүлд гарч байв. Мөн эрх баригч нам Үндсэн хуулийн шинэ төсөл боловсруулах, намын мөрийн хөтөлбөрийг шинэчлэх ажилд оржээ.

1988 оны 12 дугаар сард МАХН-ын V бүгд хурал хуралдаж “...эдийн засаг, улс төрийн систем, нийгэм, оюун санааны хүрээг бүхэлд нь хамарсан өөрчлөн байгуулалт хийх нь манай ард түмний хойшлуулашгүй зорилт болж байна” хэмээн дүгнэж, улс төрийн системийг ардчилах, нийгмийн удирдлагын захиран тушаах арга барилыг арилгах, хэт төвлөрөлийг задлах, эдийн засгийн механизмыг боловсронгуй болгох, өмчийн үр өгөөжтэй хэлбэрүүдийг оновчтой хослуулах, хоршооллын хэлбэрүүдийг дэмжих зэрэг асуудлыг дэвшүүлэн тавьжээ. Намын Төв Хорооны V бүгд хурлын үзэл санаа олон түмний улс төрийн идэвхийг эрс өрнүүлжээ.

Монголын нийгэмд өөрчлөн байгуулалтын үзэл санаа соёолох хөрс бэлэн, түүнийг тарьж ургуулах олон нийтийн тэмцэл өрнөж, эсвэл, холбоод байгуулагдан, зорилтоо тодорхойлж, хэрэгжүүлэх алхмаа хийж эхэлсэн юм. Өөрчлөн байгуулалтын үзэл санаа, олон нийтийн тэмцэл хөдөлгөөн хоёр хамтдаа өсч, үйл ажиллагаа, үзэл бодлын цэгцрэл, нэгдэл зэрэгцэн бүрэлдэж байв. Ардчилсан хүчнээс олон түмэнд хандан гаргаж байсан уриалга, лоозон, төр засагт тавьж байсан шаардлагын агуулга нь эхэн үедээ тухайн үеийн төр засгийн эрх баригчдын үйл ажиллагааг шүүмжлэх, өнгөрсөн түүхэн замналаа үнэлж дүгнэхдээ бодитой хандах, хөрш орнуудтай харилцах тэгш бус харилцааг засаж залруулах, улмаар нам, төрийн удирдлагыг огцруулах зэргээр нийгмийн тоталитари тогтолцооны эсрэг чиглэсэн хандлагатай байв.

Социалист орнуудын хэмжээнд улс төр-онолын сэтгэлгээнд ч өөрчлөлт гарч эхлэв. Тухайлбал, Шинжлэх ухааны коммунизмын онолын зарим асуудлыг эргэн харж, хөрөнгөтөн орнуудад хөгжсөн улс төр судлалын зарим ойлголт, категориудыг уг онолын хүрээнд судлах, хэрэглэх болсон байна. 1980-аад оны II хагаст ардчилал, улс төрийн систем, улс төрийн соёл, улс төрийн хүмүүжил, улс төрийн хошуучлал зэрэг асуудлыг илүү сонирхон судлаж, эрдмийн зэрэг хамгаалж, ном, өгүүлэл бичиж эхэлсэн юм. МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Д.Сүхбаатарын нэрэмжит Намын дээд сургуульд 1989-1990 оны хичээлийн жилд Улс төр судлалын төвийг байгуулан, “Улс төр судлал” хэмээх хичээлийг зааж эхэлжээ. Академич Ж.Болдбаатар дурсан ярихдаа: “...Би ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны академиас зохион байгуулсан нэгэн эрдэм шинжилгээний хуралд (1988) оролцож, тус академийн Олон улсын харилцааны төвийн захирал, профессор Ю.Красин, профессор Ю.Н.Гаврилов, ШУКО-ын тэнхимийн удирдагч, профессор Халипов нартай уулзахад улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх шаардлага тулгарч байгааг тайлбарлаад, ШУКО-ын тэнхмээ Улс төр судлалын тэнхим болгон өөрчлөн зохион байгуулж байгаа тухай ярьсан юм. Танайх ч ийм чиглэл барих нь зүйтэй хэмээн зөвлөв. Ирээд Намын Төв Хороо, сургуулийн удирдлагад танилцуулахад дэмжсэн. Ингэж Монголд анх удаа Улс төр судлалын төвийг байгуулж, би эрхлэх болсон билээ. Манай төвд А.Цанжид, Ч.Ган-Өлзий, Д.Ганбат, П.Доржсүрэн, Г.Чулуунбат, А.Пагма зэрэг залуус ажиллаж байв”²⁶ гэжээ.

²⁴ М.С.Горбачев. Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ. Манай оронд болон дэлхий дахинд. УБ. 1988.х-315.

²⁵ Монгол Ардын Хувьсгалын Намын XIX их хурал. (Дэлгэрэнгүй тайлан). УБ. 1986.х-73.

²⁶ 2015 оны 8 сард академич Ж.Болдбаатартай хийсэн ярилцлагаас.

Эхлээд Нийгмийн ухааны академиас профессор урьж багш нартаа хичээл заалгаж, А.Цанжид Польшийн их, дээд сургуульд үздэг “Улс төр судлал” сурах бичгийг монгол хэлнээ орчуулж, анхны гарын авлага болгожээ.

Тус сургуульд “Улс төр судлал”-ын хичээлийг заах явцдаа багш нар бага боловч туршлагажиж гарын авлага сурах бичиг бэлтгэж эхэлсэн байна. Чингээд 1992 онд “Улс төрийн шинжлэх ухааны үндэс” хэмээх товч сурах бичгийг доктор А.Цанжидын удирдлагаар бичиж хэвлүүлжээ. Эл номын өмнөх үгэнд: “Эл ном улс төрийн шинжлэх ухааны талаар сургалтын ажилд зориулан манай оронд гарч байгаа анхны оролдлого учраас түүнийг бичих явцад арга зүйн шинжтэй болон бусад бэрхшээл нэлээд гарч байна. Тэдгээрийг даван туулахын тулд зохиогчид багагүй чармайлт гаргасан юм. Номыг бичихэд баримталсан зарчим бол:

Нэгдүгээрт, олон судлаачид улс төрийн асуудлыг юуны өмнө нийгмийн тодорхой тодорхой бүлгийн сонирхолтой холбон үзэх нь хатуу ангич байр суурийг баримтлахаас илүү зөв бодитой хэмээн үздэгийг дэмжих,

Хоёрдугаарт, бодит сонирхлыг иш үндэс болгохын зэрэгцээ улс төрийн бодлогод хувь хүний онцлог, ялангуяа сэтгэл зүйн нөлөөллийг харгалзах, энэ талаар өрнөдийн эрдэмтдийн дэвшүүлсэн онолын үндэслэлүүдийг харгалзан үзэх,

Гуравдугаарт, улс төрийн янз бүрийн үзэгдэл, үйл явдлыг зөвхөн нийгэм-эдийн засгийн формацийн тухай онолын үүднээс авч үзэн, үнэлэлт дүгнэлт өгөхөөс татгалзан, тэдгээрийг орчин үеийн соёл иргэншлийн нөхцөл байдал, шаардлагад нийцүүлэн авч үзэх зэрэг юм.

Гэхдээ дээрх зарчмуудыг анхны энэ удаагийн оролдлогоор тэр бүр тууштай баримталж чадаагүйг хүлээн зөвшөөрөх ёстой”²⁷ хэмээжээ. Энэ бүтээл бол Монголд анх удаа улс төрийн шинжлэх ухааны үндсэн ойлголтуудыг нэгтгэн авч үзэж, өөрийн гэсэн судалгааны аргыг тодорхойлсон гэж үзэж болно.

“Улс төрийн шинжлэх ухааны үндэс” энэ номонд: “Улс төрийн шинжлэх ухаан нь бусад шинжлэх ухааны нэгэн адил өөрийн үндсэн ойлголтуудтай. Тэдгээрт нийгмийн бүлэг, нийгмийн бүлгийн хэрэгцээ, сонирхол, улс төрийн үнэт зүйлс, улс төрийн хэм хэмжээ, улс төрийн үйл ажиллагаа, улс төрийн байгууллага, улс төрийн засаглал, улс төрийн бүрдэл, үзэл суртал, улс төрийн харилцаа, улс төрийн соёл, улс төрийн субъект ба субьектлэг чанар, бие хүний улс төрийн нийгэмжилт, улс төрийн үйл явц, улс төрийн систем зэрэг ойлголтууд багтдаг. Эдгээр ойлголтын нэлээд нь нийгмийн тухай бусад шинжлэх ухаанд бас бий. Гэхдээ шинжлэх ухаан тус бүрт эл ойлголтын утга, агуулгад зохих өвөрмөц онцлог байдаг нь ойлгомжтой. Улс төрийн шинжлэх ухааны ойлголтын нь бодит байдлын тусгал болохын хувьд нэг нь нөгөөтэйгээ харилцан холбоотой, нэг нь нөгөөгөөсөө урган гардаг учир тэдгээрийг тодорхойлох, ухаж ойлгоход нарийн дэс дарааг харгалзах шаардлага багагүй гардаг”²⁸ хэмээн тодорхойлжээ.

Мөн улс төрийн шинжлэх ухааны өвөрмөц аргууд-системийн арга, бихевиорист арга, жишилтийн арга, шийдвэрийн арга зэргийг тайлбарласан байна.

Тэр үеийн Намын дээд сургуульд философи, улс төрийн эдийн засаг, социологи, социалист сургаалийн түүх, ЗХУКН-ын түүх, Олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний түүх, Коммунист хүмүүжил зэрэг хичээлүүдээр улс төрийн шинжлэх ухааны зарим ойлголтуудыг өгч байсан билээ. Ялангуяа коммунист хүмүүжлийн хичээлийн дотор улс төрийн хүмүүжил хэмээх ухагдахуунийг нэлээд өргөн хүрээтэй зааж байсан юм.

1990-ээд оны эхнээс их, дээд сургуулийн марксизмын гурван бүрэлдэхүүнийг заахаас татгалзаж эхэлжээ. Тухайлбал, 1990-1991 оны хичээлийн жилээс МАХН-ын түүх, ЗХУКН-ын түүх, Улс төрийн эдийн засгийн ухаан, ШУКО-ын хичээлийг их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнөөс хасч, оронд нь орох шинэ хичээлүүдийн бэлтгэлийг хийж эхэлсэн байна. Энэ нь нэгдүгээрт, Монгол Улс шинэ сонголт хийж, ардчилалын замд шилжсэн, хоёрдугаарт, олон нийт, ялангуяа оюутан залуус айсуу цагийн өнгө аяст тохирсон хичээлүүдийг судлах санал гаргаж эхэлсэн явдал юм.

Сургалтын шинэ хөтөлбөрт шилжих бэлтгэлийг хангахын тулд Польш, ЗХУ-д илгээж, мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах ажил хийжээ. Чингээд МУИС-ийн ШУКО-ын тэнхмийн суурин дээр Улс төр судлалын тэнхмийг байгуулах бэлтгэл ажил 1990 онд хийсэн байна. Багш нар нэг хичээлийн жил хичээлийн төлөвлөгөө, программ боловсруулж, лекц, семинар хийх бэлтгэлээ хангажээ.

1992 онд эдүгээгийн Удирдлагын тэнхимд их, дээд сургуульд улс төр судлал заах багш нарт зориулан тусгай курс зохион байгуулжээ. Гэгээрлийн сайдын тушаалаар 1991-1992 оны хичээлийн жилд ШУКО-ын оронд Улс төр судлал, УТЭЗУ-ны оронд Эдийн засгийн онол, Марксист-ленинист философийн оронд гүн

²⁷ Улс төрийн шинжлэх ухааны үндэс. УБ. 1992. х-4.

²⁸ Мөн тэнд. х-15.

ухаан, МАХН-ын түүхийн оронд Монголын түүхийн хичээлүүдийг заах нь зүйтэй гэсэн шийдвэр гарчээ.²⁹

1991 онд МУИС-ийн захирлын тушаалаар ШУКО-ын тэнхимийн суурин дээр Улс төр судлалын тэнхим байгуулагджээ. Эл тэнхим иргэний их, дээд сургуульд байгуулагдсан улс төр судлалын гол түшиц тэнхим болсон юм. Тэнхимийн анхны бүрэлдэхүүн нь профессор Д.Содномгомбо, дэд эрдэмтэн Ш.Содном, С.Базарпүрэв, Ц.Ганболд, ахлах багш Х.Ганбаатар, кабинетийн эрхлэгч Д.Оюунчимэг, лаборант Ж.Доржпагма нар байв. Тэнхимийн эрхлэгчээр Нийгмийн ухааны факультетын декан, дэд эрдэмтэн Ш.Содном хавсран ажиллах болжээ. Тэнхимийн орлогч эрхлэгчээр Ц.Ганболд томилогдсон байна.

Тухайн үед Политехникийн дээд сургууль, УБДС, АУДС, ЦДС, ХААДС зэрэг дээд сургууль, зарим техникумын улс төр судлалын багш нар МУИС-ийн Улс төр судлалын тэнхим дээр төвлөрч, сургалт, эрдэм шинжилгээн, онол-заах аргын семинар хийж, улс төрийн шинжлэх ухааны сургалт-судалгааны тулгамдсан асуудлыг хэлэлцэж, санал бодлоо солилцож байлаа. Эхний үед (1990-ээд онд) багш нар Ф.М.Бурлацний, Ё.Вятр, А.Боднар, Т.Санистебян нарын бүтээлийг уншиж, Оросын эрдэмтдийн орчуулгын бүтээлийг голлон ашиглаж, лекц уншиж байв.

Улс оронд өрнөж буй өөрчлөлт шинэчлэлийг улс төрийн шинжлэх ухааны үүднээс дүгнэж цэгнэн шаардлага улам өсөн нэмэгдсээр байв. Ялангуяа 1992 онд Ардын Их Хурлын чуулганаар шинэ Үндсэн хууль баталснаар хүний эрх, эрх чөлөөг олон улсын эрх зүйн хэмжээнд зөвшөөрөгдсөн хэм хэмжээгээр тунхаглаж, төрийн эрх мэдлийг “засаглал хуваах онол”-ын дагуу хуваарилан, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын асуудлыг нутгийн өөрөө удирдах ёстой холбон тавьсан юм.³⁰

Мөн “Улс төрийн намуудын” тухай хууль батлагдан гарч, олон намын тогтолцоо төлөвших эрх зүйн үндэс бүрэлджээ. 1994 онд “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, 1995 онд “Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого” болон боловсролын багц хуулиуд батлагдсан билээ. иймээс Үндсэн хуулиар тунхагласан улс төрийн шинэ тогтолцоо, үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, боловсролын талаар баримтлах бодлогоор тавигдсан зорилт, шинэлэг ойлголтуудыг улс төрийн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, хэрэгжүүлэх арга замыг шинжлэх ухааныг үндэстэй боловсруулахад улс төр судлаачдын гүйцэтгэх үүрэг эрс өссөн байна.

Энэхүү тавигдаж байгаа шаардлага, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн санаачлагаар 1993 онд Улс төр судлалын анги нээх шийдвэр, улс төр судлалаар мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх эх суурийг тавьжээ. Тус тэнхим БНСУ, Герман, Польшийн сургуулиудын сургалтын төлөвлөгөөг үндэслэн, анхны сургалтын төлөвлөгөөг боловсруулжээ. Чингээд 1993-1994 оны хичээлийн жилд анхны элсэлтээ авчээ. Эхлээд 18-хан хүүхэд элсчээ. Энэ үед Цэргийн нэгдсэн дээд сургууль улс төрийн ажилтны анги нээсэн боловч элсэлт гүйцээгүй учир тэндээс хэдэн хүүхэд шилжиж ирсэн байна. Ингээд МУИС-ийн ректор 1994 оны 11 дүгээр сарын 14-ний тушаалаар улс төр судлаач мэргэжлээр бакалаврын сургалтын төлөвлөгөөг баталж, амьдралд хэрэгжүүлж эхэлсэн байна. Эл төлөвлөгөөгөөр ерөнхий суурь боловсрол олгох хичээлүүдээс гадна I ангид Улс төр судлалын удиртгал, Улс төрийн сэтгэлгээний түүх, Төр, эрхийн онол, угсаатны зүй, Нийгмийн антропологи, II ангид Улс төрийн сэтгэлгээний түүх, Монголын нийгэм, Улс төрийн сэтгэлгээний түүх, Социологийн онол, сэтгэл судлал, III курст Монголын улс төрийн түүх, харьцуулсан улс төр судлал, Төрийн гадаад бодлого, олон улсын харилцаа, Улс төрийн сэтгэл зүй, Сурган хүмүүжүүлэх ухаан, Нийгэм судлал заах арга зүй, Хүн ам зүй, IV курсэд Харьцуулсан улс төр судлал II, Олон улсын харилцааны эрх зүй, Улс төрийн анализ хэмээх мэргэжлийн суурь мэдлэг олгох хичээлүүдийг орох болсон байна. 1997 онд улс төр судлалын оройн анги нээн хичээллүүлжээ. Улс төр судлаачийн анги анх элсэлт авснаас хойш 18 удаа төгсөлт хийж, 1000 гаруй бакалавр зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэжээ.

Тус тэнхим 2001-2002 оны хичээлийн жилд бакалаврын сургалтын төлөвлөгөөг шинэчилж, мөрдөж эхэлсэн байна. 2002-2003 оны хичээлийн жилд магистр, докторын сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, магистрын зэрэгтэй 200 мэргэжилтэн бэлтгэж, 40 гаруй докторын зэрэгтэй эрдэмтдийг төрүүлээд байна. 2000 оны 9 дүгээр сараас СЕР хөтөлбөртэй холбоо тогтоож, зөвлөх багш ажиллуулсан юм. 2001 оны 4 дүгээр сард “Монгол дахь нийгмийн шинжлэх ухааны сургалтын агуулгын шинэчлэлийн төлөвлөгөө” (Оюутан төвт шинэчлэлийн багц төслийг) өргөн барьж, СЕР-д хандаж, улмаар МУИС, Нээлттэй Нийгмийн Хүрээлэнгээс дэмжлэг авч, 2001 оны намраас туршилтын буюу бэлтгэл ажлын хоёр жилийн төсөл хэрэгжүүлж, 2003 оноос “Монгол дахь нийгмийн шинжлэх ухааны сургалтын агуулгыг боловсронгуй болгох оюутан төвт шинэчлэлийн багц төсөл” нэртэйгээр Социологийн тэнхимтэй хамтран хэрэгжүүлсэн байна. Тус тэнхим Нийгмийн шинжлэх ухааны сургууль дээр анх удаа салбарын ажилд “Хөтөлбөрийн өөрийн үнэлгээ” хийж, Австралийн мэргэжилтэн багш Малкомоор экспертиз хийлгэжээ.

²⁹ Ц.Ганболд ШУКО-оос Улс төр судлал хүртэл (редактор Ё.Довчин) УБ.2012.х.-59.

³⁰ Монгол Улсын Үндсэн хууль. УБ.1992.

Улс төрийн шинжлэх ухааны сургалт судалгааны ажил өргөжин тэлж, боловсролын тогтолцоонд зохих байр сууриа эзэлж байгаагийн нэг жишээ бол МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн “Улс төр судлал” бакалаврын мэргэжлийн хөтөлбөр Боловсролын магадлан итгэмжлэх Үндэсний зөвлөлийн 2012 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрээр магадлан итгэмжлэгдсэн явдал юм. Ийнхүү нийгмийн ухааны хичээлүүдээс Монгол Улсад анх удаа магадлан итгэмжлэгдэн байгаа хөтөлбөрүүдийн нэг боллоо.

1990-ээд оны дунд үеэс улс төрийн шинжлэх ухааны магистрын зэрэгтэй боловсон бэлтгэх болов. 1996 онд анхны магистрант Ж.Мэндээ, Д.Оюунчимэг нар улс төр судлалын магистрын зэрэг хамгаалсан байна.

Улс төр судлалыг янз бүрийн мэргэжлийн хүмүүс сонирхон суралцах болж, чамгүй олон магистр төрж гарч судалгаа өргөжиж эхэлжээ. Ийм үед 1999 онд тус тэнхим анхны докторын шатны сургалтыг эхлүүлсэн байна.

Улс төр судлаач мэргэжилтэн бэлтгэх ажил МУИС-ийн хүрээнээс хальж, 1999 оноос Улсын боловсролын их сургууль дээр философи-улс төр судлалын анги, 2000 онд Шинжээч-21 дээд сургуульд социологич-улс төр судлаачийн анги, 2003 оноос Ховд их сургуульд улс төр судлаачийн анги нээжээ. Түүнчлэн Соёмбо, Чингис хаан, Их засаг зэрэг сургуулиудад ижил төрлийн мэргэжилтэн бэлтгэх болов. Ийнхүү манай улсад улс төрийн шинжлэх ухааны чиглэлээр бакалавр, магистр, докторын шаталсан сургалт бодит биелэлээ олж, төлөвшиж байна.

Улс төрийн шинжлэх ухааны сургалтын ажил гүнзгийрэхийн зэрэгцээ эрдэм шинжилгээ, судалгааны ажил өргөжжээ. Юуны өмнө багш нарыг эрдэмжүүлэх ажил идэвхжиж, улс төрийн шинжлэх ухааны анхны эрдэмтэд төрөн гарчээ. 1994 онд А.Юндэндорж “Конституционализмд шилжих үеийн Монголын улс төрийн тогтолцооны онцлог” сэдвээр шинжлэх ухааны докторын (Sc.D) зэргийг Москвагийн их сургуульд хамгаалсан байна. Харин 1998 онд УБИС-ийн тэнхмийн эрхлэгч Л.Пүрэвдорж дотооддоо анх удаа улс төр судлалаар “Улс төрийн хошуучлалын асуудал” сэдвээр боловсролын доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалжээ.

1997-1999 оны хичээлийн жилээс улс төрийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн ШУА-ийн ФСЭХ-д түшиглүүлэн философи, социологи, улс төр судлалаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулагдсан. Энэ зөвлөл дээр Л.Пүрэвдорж, Ю.Атар, Х.Цолмон, Т.Гантулга нар хамгаалжээ.

1999 онд МУИС-ийн улс төр судлалын тэнхмийн багш Ё.Довчин Санкт-Петербургийн их сургуульд докторын зэрэг хамгаалав. 2002 онд БСШУЯ-ны сайдын 32-р тушаалаар улс төрийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах улсын хэмжээний нэгдсэн зөвлөл байгуулагджээ. Энэ зөвлөл философи, улс төр судлалын чиглэлээр докторын зэрэг хамгаалуулдаг нэгдсэн зөвлөл байсан юм. Энэ нь улс судлаачдын тухайд докторын зэргийн сургалт явуулах, улмаар хамгаалуулах эрхээ баталгаажуулахад нэг том алхам болсон юм.

2003 онд УТШУ-аар доктор хамгаалуулах дагнасан зөвлөл байгуулагдсан ба зөвлөлийн зарим гишүүд өөр ажилд томилогдож нилээд өөрчлөлт гарсан учир дахин шинэчилсэн. Цаашдаа ч байж байн шинэчлэгддэг боллоо. Сүүлийн үед БСШУЯ-наас хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилохдоо улс төржих хандлага ажиглагдаж байгааг яасан ч зөвтгөж болохгүй³¹ хэмээн профессор Ц.Ганболдын бичсэнтэй санал нэг буюу.

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш судалгааны ажилд шимтэн зүтгэсний үр дүнд бараг зуун хувь докторын зэрэг хамгаалжээ. Сүүлийн 10 гаруй жилд хамгаалсан хүмүүсийг дурдвал: Ё.Довчин “Ардчилалд шилжих үеийн улс төрийн соёл” (1999), Ж.Төртогтох “Монголын Үндсэн хуулиудийн политологийн шинжилгээ” (2002), Ч.Өлзийсайхан “Ардчилсан шилжилтийн үеийн Монголын улс төрийн элитийн төлөвшил” (2008), Ц.Батболд “Төрийн удирдлагын бюрократ, загварын мөн чанар, түүний улс төрийн системд эзлэх байр суурь, хэтийн төлөв” (2008), С.Мөнхбат “Монголын улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын төлөвшил” (2009), Д.Ундрах “Парламентын ёс зүйн төлөвшил” (2015) сэдвээр тус тус доктор (Ph.D) зэрэг хамгаалсан байна. Эдүгээ тус тэнхмийн профессор, багш нар Монголын улс төр, улс төрийн систем, сонгуулийн тогтолцоо элит судлал, улс төрийн соёл, үндсэн хуулийн политологийн шинжилгээ, бюрократизм зэрэг олон асуудлаар судалгаа хийж байна. Судалгааныхаа үндсэн дээр нэгэн сэдэвт зохиол, ном, товхимол түүнчлэн гарын авлага, сурах бичиг зохион нийтлүүлж байна. Энд юуны түрүүнд, Улс төр судлалын тэнхмийн багш нар 2001 онд “Улс төрийн шинжлэх ухаан” сурах бичгийг хэвлүүлснийг тэмдэглэж болох юм.

Энэхүү номонд улс төр судлал-шинжлэх ухаан болох, улс төрийн сэтгэлгээний эх үндэс улс төрийн шинжлэх ухааны үндсэн парадигмууд, улс төрийн засаглал, улс төрийн бодлогын социал үндэс, улс төрийн хошуучлал, нийгмийн улс төрийн систем, төр, улс төрийн нам, намын систем, улс төрийн соёл, улс төрийн оролцоо, геополитик* зэрэг улс төрийн шинжлэх ухааны үндсэн ухагдууныг орос, англиар хэвлэгдсэн

³¹ Ц.Ганболд. ШУКО-оос улс төр судлал хүртэл. УБ.2012.х-67.

сүүлийн үеийн ном, зохиол, материал дээр тулгуурлан бичсэн байна.³² Эл сурах бичиг нэмж засварлагдсан дөрвөн ч удаа хэвлэгджээ. Мөн доктор С.Базарпүрэвийн улс төрийн шинжлэх ухааны мэргэжлийн удиртгал, мэргэжлийн бус ангиудад зориулсан товч сурах бичиг гарсан байна.

Мэргэжлийн ангиудад зориулсан ном сурах бичиг ч гарах болов. Тухайлбал, Ё.Довчингийн “Харьцуулсан улс төр”, А.Жамбалын “Улс төрийн сэтгэлгээний түүх”, Х.Ганбаатарын “Дундат зууны үеийн сэтгэлгээний түүх”, Ч.Өлзийсайханы “Элит судлал”, Ц.Ганболдын “Улс төрийн сэтгэл судлал”, А.Юндэндорж, Ю.Атар нарын “Өрнө дорнын сэтгэгчдийн улс төрийн номлол” зэрэг бүтээлийг дурдаж болох юм.

Сүүлийн жилүүдэд тус тэнхмийн багш нар Ё.Довчин “Улс төрийн соёл” (Орос хэл дээр 2001), Ж.Төртогтох “Үндсэн хуулийн политологи шинжилгээ”, Ц.Батболд “Бюрократ онолын үндэс” (2013), Ч.Өлзийсайхан “Монгол дахь ардчилсан шинэчлэлийн үеийн улс төрийн элитийн төлөвшил” (2013) зэрэг нэгэн сэдэвт зохиол бичжээ.

Тус тэнхмээс олон улсын ISSN нэгдсэн дугаартай “Политологи” сэтгүүл гаргаж, профессор, багш нар, судлаачид, магистрант, докторантуудын судалгааны ажлын үр дүн, өгүүлэлүүдийг нийтэлж байна.

Багш Д.Бадамдаш Америкийн Улс төрийн шинжлэх ухааны холбоонд гишүүнээр элсэж, доктор Ж.Төртогтох Азийн улс төрийн судалгааны консерциумтай холбоо тогтоон хамтран ажиллаж байна. МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш нар сүүлийн 10 гаруй жилд давхардсан тоогоор 60 гаруй удаа 20 орчим оронд урт, богино хугацаагаар томилолтоор ажиллажээ.

Улс төр судлалын салбар, тэнхмийн гадаад харилцаа өргөжиж ирсэн нь Монгол оронд улс төрийн шинжлэх ухаан өрнөн хөгжих нөхцлийг бүрэлдүүлсэн юм. Тус салбар өсөн бэхжихэд Соросын сан, СЕР, ТЕИС, Конрад-Аденаурын сан, Ханс Зайдлын сан, Эйбертийн сан, Азийн сан зэрэг олон улсын байгууллагууд туслалцаа дэмжлэг үзүүлж ирэв.

Эдгээр байгууллага улс төр судлаачдыг гадаадын мэргэжил нэг байгууллага, судлаач эрдэмтэдтэй холбоо тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Улс төр судлалын салбарыг профессор, багш нар, судлаачид АНУ, Канад, Герман, Англи, Унгар, Польш, Литва, Казахстан, Киргизстан, Узбекистан, Япон, Солонгос, Хятад, Сингапур зэрэг Ази, Европ, Америк зэрэг олон оронд суралцаж, мэргэжил дээшлүүлэн, эрдмийн зэрэг хамгаалж иржээ.

Тус салбар, тэнхим 2005 оноос Олон Улсын улс төрийн шинжлэх ухааны холбоотой ажил төрлийн холбоо тогтоож, мэргэжлийн сэтгүүл, шинэ мэдээ, мэдээлэл авдаг болжээ. Улмаар тус холбоонд элсэх саналаа илгээж, 2005 онд тэнхмийн эрхлэгч, доктор, профессор Ц.Ганболд IPSA-ийн гишүүн болж, 2006 онд Японы Фукуока хотод хуралдсан IPSA-гийн дэлхийн XX их хуралд Монголоос анх удаа оролцжээ.

Тус тэнхмийн эрхлэгч Ц.Ганболд 2012 оны 7 дугаар сарын 7-13-ны өдрүүдэд Испани улсын нийслэл-Мадрид хотноо болсон Улс төрийн шинжлэх ухааны Дэлхийн XXII их хуралд урилгаар оролцжээ. Тус хуралд “Монгол дахь ардчиллын мөн чанар” сэдвээр илтгэл тавьсан байна.

1998 онд Улс төр судлалын тэнхмийн дэргэд сургалт, судалгааны АЛЬТЕРНАТИВ төв байгуулагджээ. Эл төв “Монгол орны өнөөгийн нийгэм, эдийн засаг улс төрийн байдал ба олон нийтийн санаа бодол”, “Монголын парламентын гишүүдийн имиджийн өнөөгийн байдал”, “Сонгууль ба улс төрийн нам хүчнүүд” зэрэг сэдвээр цуврал судалгаа явуулж иржээ. Мөн төвийн шугамаар лекц зохион байгуулж, судалгааны семинарыг тогтмолжуулан, Улс төрийн шинжлэх ухааны Альтернатив сэтгүүлийг эрхлэн гаргаж байна.

Сүүлийн жилүүдэд улс төр судлаачдын хамтын ажиллагаа өргөжиж, мэргэжлийн холбоонд нэгдэх болов. 2003 онд Монголын Улс төр судлалын холбоог байгуулжээ. Тус холбооны дүрэмд: “Холбоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Төр бус байгууллагын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад

³² Улс төрийн шинжлэх ухаан. УБ.2001.

* Шведийн эрдэмтэд Рудольф Челлен (1864-1922) шинжлэх ухаанд анх “геополитик” гэсэн ойлголтыг оруулж ирсэн. Энэ ухааныг тэр “Улс орныг газарзүйн биет буюу орон зайн үзэгдэл гэж үзэх сургааль” гэж тодорхойлсон. Үүнийг Германы “Zeitschrift für Geopolitik” сэтгүүлд их нарийн тодорхойлсон байдаг. Геополитик нь дэлхийн улс төрийн үйл явдлуудын харилцааны тухай шинжлэх ухаан. Тэр газарзүйн суурин дээр, ялангуяа орон зай дахь улс төрийн биет ба түүний бүтцийн тухай судалдаг улс төрийн газарзүйд тулгуурлана. Түүнээс гадна улс төрийн амьдралд бүхэлд нь чиглэл өгдөг, улс төрийн үйл ажиллагааны зорилгыг хангах хэрэгсэл юм. Геополитик нь улс төрийг практик урлаг болно. Геополитик бол төр улсын газарзүйн оюун ухаан-сэтгэлгээ юм. Геополитик улсыг тогтвортой хувирашгүй байнгын зүйл биш, харин динамик хөдөлгөөнд ордог амьд зүйл гэж үздэг. Ийм хандлагыг Германы онолч (Фридрих Ратцель 1844-1904) санал болгосон. 1989 оны Зөвлөлтийн философийн нэвтэрхий толь геополитикийг сөргөөр үнэлээгүй боловч түүнийг Барууны улс төрийн үзэл баримтлал гэж тодорхойлон, “хүн амын нягтшил ба өсөлтийн хурдац, уур амьсгал, байгалийн нөөцийн илүүдэл буюу хомсдоллоор илэрхийлэгдсэн орон зай, үндсэндээ янз бүрийн газарзүйн хүчин зүйлүүдээр урьдчилан илэрхийлэгдсэн төрийн бодлогын гадаад онцлог” гэж баталдаг. Орон зайн харьцаанаас үүссэн асуудлыг шийдэх зорилгоор гаргасан, улс орны түүнийг хүрээлэн буй орчинтой харилцах харилцааг геополитик судалдаг. Геополитик улс төрийн үзэгдлүүдийн орон зайн харилцааг, дэлхий, соёлын хүчин зүйлс дэх түүний нөлөөг судална. Судалгааны талбараас хамаарахгүй, улс төрийг газарзүй (утгаар илэрхийлэх)-гээр тайлбарлах завсрын шинжлэх ухаан юм. Улс төрд их татагддаг, улс төрийн үзэгдлүүдэд анхаарал нь төвлөрдөг, тэдгээр үзэгдлийн газарзүйн аспектиудад дүн шинжилгээ хийж, газарзүйн тайлбар өгөхийг оролддог. Улс төр судлаач Э.А.Поздняков геополитик бол улс орны эдийн засгийн ба экологийн аюулгүй байдал, цэрэг-улс төрийн сонирхолд нөлөөлөх, физик орчны хүчин зүйлсийг идэвхтэй ашиглах бодлогын боломжийг нууцаар судлахад гол анхаарлаа чиглүүлдэг гэж баталдаг.

акт болон энэ дүрмийн хүрээнд Улс төрийн шинжлэх ухааныг судалдаг сонирхдог иргэдийг нэгтгэн үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус, аль нэг улс төрийн хүчин, нэр дэвшигчийг дэмжихгүй, улс төрийн хүчнээс хараат бус нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага мөн”³³ гэж тодорхойлжээ.

МУИС-ийн Улс төр судлал, Эрх зүйн онол, Түүхийн тэнхмийн залуу багш нарын санаачилгаар 2006 оны 5 дугаар сарын 10-нд МУИС-ийн захирлын тушаалаар Орчин үеийн улс төрийн судалгааны төвийг байгуулсан байна. Энэ төв судалгаа хийх, хурал, семинар, симпозиум зохион байгуулах, эрдэм шинжилгээний сэтгүүл, зөвлөмж гаргах, гадаад харилцааг өргөжүүлэх зэргээр 2006-2011 онд ажилласан байна.

ШУА-ийн улс төр судлалын салбарын үндэс анх 1978 онд Шинжлэх ухааны социализмын онолын сектор нэртэйгээр тавигджээ. Марксизмын улс төрийн сургаал хэмээгдэж байсан ШУКО-ын Монгол дахь хэрэгжилт, түүнтэй холбогдон тавигдаж байсан онолын зарим асуудлыг тус орны онцлогт нийцүүлэн судлах ажлыг тус сектор 1990 он хүртэл гүйцэтгэжээ. Улс төр судлалын салбар нь 1990 оноос эхлэн өнөөг хүртэл Монголын нийгмийн хөгжил, өөрчлөлтийн асуудал, олон нийтийн санаа бодлын өөрчлөлт, монголын улс төрийн тогтолцооны онцлог, ардчиллын төлөвшлийн асуудлыг судалгааныхаа үндсэн чиглэл болгон судлахын зэрэгцээ нийгэм улс төрийн харилцааны чухал асуудлууд болох сонгууль, сонгуулийн тогтолцоо, үйл явц, монголын улс төрийн сэтгэлгээний түүх, монголын улс төрийн ардчилсан өөрчлөлтийн онолын асуудал, улс төрийн нам, түүний дотоод ардчилал, иргэний нийгмийн төлөвшил, төлөөллийн ба иргэдийн улс төрийн оролцооны онолын асуудлуудыг суурь судалгааны сэдвийн түвшинд нарийвчлан судалдаг. Тухайлбал: “XIII-XIV зууны улс төрийн сэтгэлгээний зарим асуудал” 2004-2006, “Монголын ардчиллын туршлага, сургамж” 2008-2010, “Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал” 2011-2013, “Монгол дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо” 2014-2016, “Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт” 2007-2008, 2009-2010, “Нийслэлийн иргэн”, “Нийслэлийн сонгогчийн дүр төрх” 2012 онд хэрэгжсэн /ШУТС-ийн төсөл, “Монголын хөгжлийн үйл явцад улс төрийн соёлын гүйцэтгэх үүрэг” зэрэг бодитой үр дүнг тооцсон судалгаануудыг хийж байна. Тэнд ажилтан олон эрдэмтдээс дурьдвал: Д.Баасансүрэн “Монгол дахь сонгуулийн компанийн технологи” сэдвээр 2012, О.Хатанболд “Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс” сэдвээр 2016 докторын(Ph.D) зэрэг хамгаалсан бол Д.Болд-Эрдэнэ “Монголын улс төрийн орчин дахь нам” сэдвээр шинжлэх ухааны доктор (Sc.D) зэрэг хамгаалсан.

МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, түүний дэргэдэх төв, ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн салбаруудаас гадна Улс төрийн боловсролын академи, Төрийн Удирдлагын Академи, УИХ-ын дэргэдэх судалгааны төв, Улс төрийн намуудын дэргэдэх судалгааны байгууллагууд, МЗХ-ны дэргэдэх Полис төв, Зориг сан, Сант Марал сан, Зотол, Социологийн Академи, Сонгогчдын боловсрол төв, Сивикус, Зөгий, Жинлүүр, Монголын Лектор төв зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд улс төрийн ШУ-ны тодорхой чиглэлүүдээр судалгаа шинжилгээний ажлууд хийж ирсэн нь энэ салбарын институционал бүтцийн нэг бүрдэл хэсэг болон төлөвшиж байна. Энэхүү бүтцийн хөгжилд Соросын сан, АНУ-ын БНОУХ, Азийн сан, Конрод-Адэнаурын сан зэрэг гадаад орнуудын болон олон улсын байгууллагуудын дэмжлэг, туслалцаа хамтын ажиллагаа чухал нөлөө үзүүлсэн билээ.

Ялангуяа Монгол оронд улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд Улс төрийн боловсролын академи багагүй үүрэг гүйцэтгэж байна. Тус академи улс төр судлалын цуврал лекцүүд гаргаж, улс төр судлалын гарын авлагууд хэвлүүлжээ. Мөн “Шинэ толь” сэтгүүл гаргаж, улс төрийн амьдралын амин чухал асуудлаар онол-практикийн өгүүллүүд нийтлэж байв. Ийнхүү Монголд улс төрийн шинжлэх ухааны хөгжил хүчээ авч, хүн ардыг улс төрийн талаар нийгэмшүүлэх, хүн төрөлхтний улс төрийн амьдралын жам ёсны гольдролоор хөгжих онол, практикийн хүчирхэг хүчин зүйл болон өсөн дэвшиж байна.

Гэхдээ Монгол оронд улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлж, улс төрийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлэхийн тулд:

- Бүх нийтэд улс төрийн боловсрол олгох улсын хэмжээнд шинжлэх ухааны үндэстэй нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх,
- Улс төрийн шинжлэх ухааны бакалавр, магистр, доктор бэлтгэх сургалтыг олон улсын жишигт хүргэх,
- Улс төрийн шинжлэх ухааны ойлголт, ухагдахууныг монгол хөрсөн улам нарийн буулган, судалгааг гүнзгийрүүлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд улс төрийн бодлогод дүн шинжилгээ хийж, холбогдох өндөр дээд албан тушаалтанд ажил хэрэгч зөвлөмж өгөх улс төрийн анализын орон тооны хамтлаг (төв) байгуулах,
- Улс төр судлаачид УИХ-ын болон Засгийн газрын гишүүдийн улс төрийн хэм хэмжээнээс хэтэрсэн, овилгүй үйлдлийг шинжлэх ухааны үндэстэй няцааж, үнэн нүүр царайг илчилж байх,
- Олон улсын Улс төр судлалын шинжлэх ухааны холбоотой ажил хэрэгч холбоо тогтоож, Улс төрийн шинжлэх ухааны Дэлхийн их хурлуудад тогтмол оролцож, улс төрийн шинжлэх ухааны тулгамдсан

³³ Ц.Ганболд. ШУКО.оос Улс төр судлал хүртэл.УБ.2012.х-81.

асуудлыг судлахад монголын талын оролцоог эрс нэмэгдүүлэх зэрэг тулгамдсан асуудлууд дэвшигдэж байна.

МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. (1920-1940 он) I дэвтэр. УБ.1966.х-9.

Мөн тэнд.х-7.

Мөн тэнд.х-32.

МАХН-ын Их, бага хурал, ТХ-ны бүгд хурал, ТХ-ны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр. I хэсэг (1921-1939). УБ.1956.т.33.

Мөн тэнд.т.31,32,33,89.

Мөн тэнд.т.115.

Б.Ширэндэв. Далайн давалгаанаар. УБ.1993.х-161-162.

Оюун сэтгэлгээний цоморлиг. (ХХ зуун) УБ.2013.х-36-37.

О.Бямбажав. Ухуулга, суртал нэвтрүүлгийн онол-практик-арга зүйн асуудал. УБ.1976.х-27.

Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх. (Нэмж засварласан гурав дахь хэвлэл). УБ.1985.х-115.

Abstract: In my presentation I'd like to stress on historic role of political science for Mongolia. For that reason, I studied periodically about the system, through which political education taught to well-trained staff, and secular political education taught under Mongolian Republic Revolutionary Party in the name of Marx method and theory through the framework such as political agitation, advertisements, and books, parties, unions and Mongolian Revolutionary Youth.

НОМ ЗҮЙ:

1. А.Жамбал. 1920-иод оноос 1980-аад оны үед Монголд хийгдсэн улс төрийн судалгааны тухайд. "Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжил, хандлага" (Эрдэм шинжилгээний бага хурал. УБ.2010)
2. Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх (Нэмж засварласан гурав дахь хэвлэл). УБ.1985
3. Ш.Шагдар. Монголын боловсролын түүх. (Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ.2009)
4. Монгол Ардын Хувьсгалт Намын VII их хурал. (Дэлгэрэнгүй тайлан) УБ.
5. МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1947 оны 2 дүгээр сарын I-ний өдрийн 5 дугаар хурлын тогтоол.
6. Нийгмийн шинжлэх ухааны сургууль. (Түүхэн тойм, баримтын эмхтгэл) Нэмж засварласан 2 дахь хэвлэл. УБ.2012
7. ХХ зууны дэлхийн түүх. УБ.2001.
8. Ю.В.Андропов. Карл Марксын сургаал ЗСБНХУ-ын социалист байгуулалтын зарим асуудал. УБ.1983
9. М.С.Горбачев. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг. УБ.1986
10. М.С.Горбачев. Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ. Манай оронд болон дэлхий дахинд. УБ.1988
11. Монгол Ардын Хувьсгалын Намын XIX их хурал. (Дэлгэрэнгүй тайлан). УБ.1986
12. 2015 оны 8 сард академич Ж.Болдбаатартай хийсэн ярилцлагаас.
13. Улс төрийн шинжлэх ухааны үндэс. УБ.1992
14. Ц.Ганболд. ШУКО-оос Улс төр судлал хүртэл. (редактор Ё.Довчин) УБ.2012
15. Монгол Улсын Үндсэн хууль. УБ.1992.